



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

БОЛОВСРОЛ СУДЛАЛ



Боловсрол судлал

Боловсрол судлал

ISSN-1818-8478

Дугаар 25 (589)

2023 оны 11-р сар

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

№ 25 (589)

<http://setguul.num.edu.mn>

Улаанбаатар хот

2023 он

Боловсрол судлал

№25 (589)

Editorial Board:

1. Amy B.M. Tsui, Ph.D., prof., Faculty of education, The University of Hong Kong
2. Yurawat Klaimongkol Ph.D., prof., Faculty of Education, Chulalongkorn University
3. Mei-Hung Chiu Ed.D., Distinguished Professor, Graduate Institute of Science Education, National Taiwan Normal University
4. Yoshiaki Shibata Ph.D., prof., Graduate School of Education and Human Development, Nagoya University
5. Sakamoto, Masanoba Ph.D., ass. prof., Graduate School of Education and Human Development School of Education, Nagoya University
6. Timothy K. Shih, prof., National Central University, Taiwan
7. Lin Hui, prof., Tamkang University, Taiwan
8. Yung-Hui Chen, prof., LungHwa University of Science and Technology, Taiwan
9. Zayabaatar. D, Ph.D., prof., Director, School of Arts and Sciences, NUM
10. Amartaivan, Ts, Ph.D., prof., Dean for Division of Natural Sciences, School of Arts and Sciences, NUM
11. Amarzaya. A, Ph.D., ass.prof., Department of Mathematics, School of Arts and Sciences, NUM
12. Byambakhand. Ch. Ph.D., ass.prof., Department of Mongolian Language, School of Arts and Sciences, NUM
13. Davaa. J. Ph.D., ass.prof., Department of Education and Psychology, School of Arts and Sciences, NUM
14. Zoljargal. D. Ph.D., ass.prof., Foreign Language Center, NUM
15. Itgel. M. Ph.D., Department of Mathematics, School of Arts and Sciences, NUM
16. Navchaa. Ts. Ph.D., Department of Mathematics, School of Arts and Sciences, NUM
17. Nandinbilig.G. Ph.D., ass.prof., Department of Literature and Art Studies, School of Arts and Sciences, NUM
18. Nyamgerel. Ch, Ph.D., ass.prof., Department of Chemistry, School of Arts and Sciences, NUM
19. Otgontugs.B. Ph.D., ass.prof., Department of Economics, School of Arts and Sciences, NUM
20. Oyungerel. Sh, Ph.D., ass.prof., Department of Biology, School of Arts and Sciences, NUM
21. Tumenbayar. D, Ph.D., ass.prof., Department of Mathematics, School of Arts and Sciences, NUM
22. Khishignyam. B. Ph.D., ass.prof., Department of Education and Psychology, School of Arts and Sciences, NUM
23. Yumchmaa. G. Ph.D., ass.prof., Department of Geography, School of Arts and Sciences, NUM

Managing Editor: Navchaa. Ts. Ph.D., Department of Mathematics, School of Arts and Sciences, NUM

Цаасны хэмжээ: А4

Хэвлэгдсэн тоо: 30 ш

Хэвлэлийн хуудас: 7.5 х.х.

ISSN: 1818-8478

ГАРЧИГ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших эрх зүйн орчны судалгаа <i>У.Туяа, Э.Эрдэнэхишиг, Э.Оюунчимэг</i>	4
Төрийн өмчийн их сургуулиудын хяналтын интерактив тогтолцооны харьцуулсан судалгаа ... Comparative study of public universities' interactive control system <i>Д.Баярмаа</i>	23
Сайн багшийн тухай ойлголт: байгаль-эх лицей ахлах сургуулийн жишээн дээр <i>Б.Булгамаа, Ц.Амартайван, Б.Хишигням</i>	42
1-3-дугаар ангийн математикийн сурах бичгийн даалгаврын шинжилгээ <i>Д.Түмэнбаяр, Б.Отгонжаргал, Х.Ганчимэг</i>	52

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

У.Туяа^{1*}, Э.Эрдэнэхишиг², Э.Оюунчимэг³

¹ Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
*tuuya@mnieer.mn

² “Өмгөөллийн Ивээл баг” ХХН
iveelbaglawfirm@gmail.com

³ Боловсролын үнэлгээний төв
oyunchimeg@eec.edu.mn

Хураангуй

Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлэх шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (ХБХ)-ийн боловсрол эзэмшихтэй холбоотой харилцаа нь өргөн хүрээтэй, онцлог зохицуулалт шаардсан байх тул эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарын бодлого, хууль тогтоомжоор зохицуулагдаж байна. Бид энэхүү харилцаанаас эрх зүйн зохицуулалт шаардлагатай гэж үзсэн харилцааг ялгаж хэд хэдэн шалгуураар шинжилсэн бөгөөд энэхүү өгүүллээр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах, хөгжихөд шаардлагатай дэмжлэг, туслалцаа авах бодлого, зохицуулалт”¹ гэсэн шалгуураар хийсэн шинжилгээний үр дүнг танилцуулж байна. Энэ хүрээнд төрөөс баталсан хууль тогтоомж цөөнгүй байгаа бөгөөд тэдгээрийн уялдаа холбоотой эсэх, давхардал, хийдэл үүссэн эсэх, оролцогчдын эрх үүргийг оновчтой, тодорхойлсон эсэхийг авч үзэх нь цаашид ХБХ-ийн сурч боловсрох эрхийг хангах хамгаалах, эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад ач холбогдолтой гэж үзлээ.

Түлхүүр үг: хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших харилцаа, тэгш хамруулах боловсрол, сургалтын тохирох орчин, тохируулгат хэрэгсэл

Удиртгал

ХБХ-ийн боловсрол эзэмшихтэй холбоотой харилцааг цөөнгүй хууль тогтоомжоор зохицуулж байна. Эдгээр эрх зүйн баримт бичиг нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, хууль тогтоомжид нийцсэн, боловсролын харилцаанд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага ойлгомжтой, тодорхой тусгагдсан байх нь ХБХ-ийн сурч боловсрох эрхийг хангах, хамгаалах үүргээ гүйцэтгэж байна хэмээн үзэх боломжтой болно. Бид энэхүү өгүүллээр “ХБХ боловсрол эзэмшихэд төрөөс үзүүлэх шаардлагатай дэмжлэг, сургалтын тохирох орчин, тохируулгат хэрэглэгдэхүүн болон бусад дэмжлэгийн эрх зүйн зохицуулалт”-тай холбоотой

¹ Энэхүү судалгааны өгөгдөл мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны Сайд (БШУС)-ын тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (ХБХ)-ийн боловсрол эзэмших харилцаатай холбоотой Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бодлогын болон эрх зүйн баримт бичигт шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулах” ажлын хүрээнд цуглуулсан болно.

шинжилгээний үр дүнг авч үзсэн нь уг асуудал нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал болон иргэд зэрэг олон талын оролцогчийг хамардаг, ХБХ боловсрол эзэмших эрхээ эдлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлдэгтэй холбоотой юм. Тухайлбал, шинжилгээнд авсан хууль тогтоомжуудад ХБХ-ийг сурч боловсрох эрхийг хангах, хамгаалах үүрэг хүлээсэн 20 субъект илэрсэн нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан, хамтарсан зөвлөл болон эцэг, эх байна.

Шинжилгээгээр Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй ХБХ-ийн боловсрол эзэмших эрхийг хангах, хамгаалахтай холбоотой бодлогын болон эрх зүйн баримт бичигт тодорхой үзүүлэлт боловсруулан шинжилгээ хийж, дүгнэлт гаргахыг зорилоо. Ингэхдээ мөн эрх зүйн зохицуулалт нь нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, хууль тогтоомжид нийцсэн эсэх, тэгш хамруулан сургах үзэл санаа, ХБХ-ийг боловсролд тэгш хамруулах асуудлаар НҮБ-аас тусгайлан гарсан 4-р Ерөнхий зөвлөмж, Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан (БХШДТ)-д дурдсан зарчмыг хангахуйц байгаа эсэхийг авч үзэхийг оролдсон болно.

Сэдвийн судлагдсан байдал

Монгол улсын ХБХ-ийн боловсрол эзэмшихтэй холбоотой эрх зүйн харилцааны зохицуулалтыг тусгайлан судалсан эх сурвалж харьцангуй цөөн байна. Бид энэхүү шинжилгээний хүрээнд олон улсын болон дотоодын зарим судалгаа, үнэлгээний материалыг авч үзсэн болно.

Хүснэгт 1. Судалгаа/үнэлгээний дүгнэлт, зөвлөмж

№	Судалгаа/үнэлгээ	Он	Байгууллага	Бодлого, зохицуулалттай холбоотой онцлох дүгнэлт/ зөвлөмж
1.	Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь судалгааны тайлан	2020	АХБ	<ul style="list-style-type: none"> - тэгш хамруулах боловсролыг дэмжих тогтолцоо (зохицуулалт) Монгол Улсад хөгжлийн эхний шатандаа байна. ... авч буй арга хэмжээнүүд нь хараахан бүрэн дүүрэн үр дүнтэй биш эсвэл бүрэн хэрэгжээгүй гэдгийг харуулж байгаа юм. - үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй 10 хүүхэд тутмын найм нь дунд эсвэл хүнд түвшний бэрхшээлтэй байна. - хууль тогтоомжид нийцсэн дүрэм журам байхгүй (5); - (vii) сургуулийн удирдлага, багш нар болон бусад ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хамруулахаас татгалздаг (4); - (viii) багш, ажилтнуудын сөрөг хандлага (1).
2.	Тэгш хамруулсан боловсрол эзэмших эрхийн талаарх 4-р Ерөнхий зөвлөмж	2016	НҮБ, ХБХ-ий эрхийн хороо	<ul style="list-style-type: none"> - Нарийвчилсан задаргаатай тоон мэдээлэл, судалгаа (эгэх хариуцлагатай байх, хөтөлбөр боловсруулахад нэгэн зэрэг шаардлагатай) хангалтгүй байгаа нь тэгш хамруулсан, чанартай боловсролыг хөхиүлэн дэмжих үр дүнтэй бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг авахад саад болж байна.

				<ul style="list-style-type: none"> - Зөрчигдсөн эрхийг сэргээх, эрхийн зөрчлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах эрх зүйн механизм байхгүй байна. - хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш хамруулсан, чанартай, үнэ төлбөргүй бага ба дунд боловсрол эзэмших, дээрх хоёр түвшний хооронд түвэггүй шилжих боломжтой байх ёстой. Хороо Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны зөвлөмжид дурдсанаар дээрх үүргээ биелүүлэхийн тулд хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, уян хатан байх гэсэн хоорондоо харилцан холбоотой дөрвөн шинжийг боловсролын тогтолцоондоо агуулсан байх ёстой - ...тэгш хамруулсан боловсролыг дэмжихүйц салбар хоорондын, уялдаа холбоотой бүтэцгүй байх, шинээр элссэн, улирсан, ахисан тухай нарийвчилсан мэдээлэл цуглуулахгүй, мөн тэгш хамруулсан багшийн боловсролыг хөгжүүлэхгүй орхигдуулж байна.
3.	НҮБ-ын ХС-ийн УОХ-ийн үнэлгээ*	2018	НҮБ-ын ХС	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын тэгш хамруулах боловсролын загвар байхгүй - ... нэг сурагчид ногдох хувьсах зардлаар тооцдог санхүүжилтийн талаарх бодлогыг тэгш хамруулах боловсролын үүднээс хянан үзэж, хэрэв тэгш хамруулах боловсролыг дэмжсэн нэмэлт хувьсах зардлыг санхүүжүүлэх боломжтой болбол түүнийг хэрхэн зарцуулах талаарх заавар журмаар сургуулиудыг хангах
4.	МУ-ын тэгш хамруулах боловсролын бодлого болон үйл ажиллагаанд хийх үнэлгээ	2021	БХБТЭ	<ul style="list-style-type: none"> - Боловсролын багц хуульд НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц болон түүнийг дагалдан гарсан 4 дүгээр Ерөнхий зөвлөмжийн тэгш хамран сургах зарчим, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дэвшилтэт үзэл санааг тусган тэгш хамруулах боловсролыг хуульчлан баталгаажуулах

Судалгааны арга зүй

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжийн хүрээнд баримт бичгийн агуулгын шинжилгээний арга аргачлалыг ашиглан шинжилгээ хийсэн. Ингэхдээ ХБХ-ийн боловсрол эзэмших харилцааны эрх зүйн зохицуулалтад хамаарах харилцааг ялган, уг харилцааны хүрээнд үүсээд байгаа асуудлыг шинжилгээний шалгуур гэж үзэн, шалгуур тус бүрд 2-4 үзүүлэлтийг боловсруулан шинжилгээнд ашиглалаа. Асуудлыг тодорхойлохдоо судлагдсан байдлын хүрээнд танилцуулсан судалгаа/үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэсэн бол үзүүлэлтийг боловсруулахдаа Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль, түүнийг дагаж батлагдсан зарим аргачлал, Захиргааны ерөнхий хуулийн захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлага зэргийг судлан үзэж, судалгааны зорилгод нийцүүлсэн болно.


Хүснэгт 2. Шинжилгээнд авсан баримт бичгийн жагсаалт

Д/д	Бодлогын баримт бичиг, хууль, захиргааны актын нэр	Баталсан субъект	Баталсан он, сар, өдөр	Тайлбар
1.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	УИХ	2020.05.13, 52-р тогтоол	Бодлогын баримт бичиг
2.	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”		2020.08.28, 23-р тогтоол	
3.	“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”		2020.08.28, 24-р тогтоол	
4.	Боловсролын тухай хууль	УИХ	2002.05.03	Хууль
5.	Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль		2008.05.23	
6.	Бага, дунд боловсролын тухай хууль		2002.05.03	
7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль		2016.02.05	
8.	Нийгмийн халамжийн тухай хууль		2012.01.19	
9.	Хүүхдийн эрхийн тухай хууль		2016.02.05	
10.	Хүүхэд хамгааллын тухай хууль		2016.02.05	
11.	Гэр бүлийн тухай хууль		1999.06.11	
12.	Эрүүл мэндийн тухай хууль		2011.05.05	
13.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль		2016.04.22	
14.	Зөрчлийн тухай хууль	2017.05.11		
15.	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлал	БСШУС	2018.03.29, А/155	Захиргааны акт
16.	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр суралцаж буй суралцагчийг үнэлэхэд баримтлах чиглэл	БСШУС	2021.09.16, А/325	
17.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам	БСШУС	2019.05.14, А/292	
18.	Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам	БСШУС	2020.12.11, А/184	
19.	Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл	БСШУС	2020.05.21, А/249	
20.	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид нэмэгдэл хөлс олгох заавар	БСШУС	2020.06.25, А/296	
21.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам	БСШУС	2021.05.13, А/177	
22.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм	ЗГ	2021.06.23, 173-р тогтоол	
23.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал	ХНХС, БШУС,	2021.12.30,	

		ЭМС	A/220, A/475, A/812
24.	Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх журам	ЭМС	2015.12.11, 487
25.	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам	БСШУС	2020.06.02, A/280
26.	Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам	ЗГ	2012.05.30, 185-р тогтоол
27.	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам	БСШУС	2009.04.16, 131
28.	“Хэл ярианы хөгжил” сургалтын жишиг хөтөлбөр	БСШУС	2020.07.01, A/305

Шинжилгээнд авсан баримт бичгийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /legalinfo.mn/-ээс татаж ашигласан бөгөөд шинжилгээг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын түвшинд хийлээ.

ХБХ цэцэрлэг, сургуульд элсэхээс албан боловсролын харилцаанд орж эхэлдэг гэж үзсэн бөгөөд сургуульд элсэх үед талуудын үүрэг, хариуцлага, суралцах үед сургалтын хөтөлбөр, анги дэвших үед үнэлгээний асуудал хэрхэн зохицуулагдсан, хүүхэдтэй ажиллах хүний нөөц хэр бэлтгэгдсэн, төгсөх, дараагийн шатны боловсролын байгууллагад элсэн суралцахад үнэлгээ, баталгаажуулалтын асуудал хэрхэн зохицуулагдсан зэрэг үүсэж болох харилцааг багтаан шинжилгээний агуулгын ерөнхий хүрээг тодорхойлсон.



Зураг 1. Шинжилгээний агуулгын ерөнхий хүрээ

Шинжилгээний агуулгын ерөнхий хүрээнд тодорхойлсон эрх зүйн харилцааг нарийвчилсан.

Хүснэгт 3. Шинжилгээний шалгуур, үзүүлэлт

Д/д	Асуудал/Шалгуур	Илрүүлэх үзүүлэлт
1.	Цэцэрлэг, сургуульд элсэх, төгсөх, шилжихтэй холбоотой зохицуулалт хангалттай бус.	Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуульд элсэхтэй холбоотой зүйл, заалт тусгагдсан эсэх: – элсэх нас – эрт оношилгоо – сургуульд бэлтгэх Сургуульд бэлтгэх, эрт оношилгоо хийх, дэмжлэг үзүүлэх зэрэг зохицуулалт тусгагдсан эсэх
2.	Суралцах, хөгжих явцад шаардлагатай дэмжлэг	ХБХ-ийн суралцах, хөгжих явцад үзүүлэх шаардлагатай дэмжлэг туслалцааг тодорхойлсон

	туслалцаа авах зохицуулалт ерөнхий бөгөөд тодорхойгүй.	байдал – Тохируулгат орчин – Тохирох хэрэглэгдэхүүн – Дэмжлэг үзүүлэх механизм – Талуудын үүрэг хариуцлага – Сургалтын хөтөлбөр, түүнийг тохируулсан байдал
		Санхүүжилтийг тусган баталгаажуулсан эсэх
		Тодорхой зөвлөмж, аргачлал боловсруулах зохицуулалттай эсэх (үүрэг болгосон)
3.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн ахиц дэвшил болон сурлагын амжилтыг үнэлэхтэй холбоотой зохицуулалт хангалтгүй.	Явцын болон үр дүнгийн (анги дэвших, ахиц амжилтыг үнэлэх) үнэлгээний зохицуулалт – үнэлгээний журамд тохируулга хийсэн байдал, тусдаа журамтай эсэх
		Сургууль төгсөх-боловсролын гэрчилгээ-баталгаажуулалтын талаарх зохицуулалт
		Өөр сургуульд шилжих болон ерөнхий боловсролын түвшин хооронд шилжихтэй холбоотой тусгайлсан заалттай эсэх
4.	ХБХ-тэй ажиллах хүний нөөцтэй холбоотой зохицуулалтыг илүү тодорхой болгох шаардлагатай.	Талуудын эрх, үүрэгт тусгагдсан байдал
		Хүний нөөцийн хөгжлийг дэмжих чиглэлээр зохицуулалт тусгагдсан байдал
5.	ХБХ-ийг боловсролд тэгш хамруулахад талуудын үүрэг хариуцлага болон хэрэгжүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ тодорхой бус.	– Талуудын үүрэг хариуцлагыг тусгасан байдал – Биелүүлээгүй бол хүлээлгэх хариуцлага – асуудал шийдвэрлүүлэх, гомдол барагдуулах журам
6.	ХБХ-ийн талаар мэдээлэл цуглуулсан байдал хангалтгүй, үзүүлэлт тодорхой биш, эрүүл мэндийн хандлагад ихэвчлэн үндэслэдэг.	– ХБХ-ийн талаар мэдээлэл цуглуулах үзүүлэлт баталгаажсан байдал – Цуглуулсан мэдээллийг хуваалцах зохицуулалт

Шинжилгээг дараах алхмаар хийхээр аргачлалыг боловсруулав. Үүнд:

Алхам 1: Асуудлыг тодорхойлох, тухайн асуудлын хүрээнд хамаарах зохицуулалтыг илрүүлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон.

Алхам 2: Тухайн шалгуурын хүрээнд зүйл, заалт байгаа эсэхийг үзүүлэлтийн дагуу бүртгэх, ингэхдээ үр дүнтэй, тодорхой зохицуулсан эсэхээс үл хамааран, холбоотой үг, өгүүлбэр илэрсэн нөхцөлд “тусгагдсан” гэж бүртгэсэн.


Алхам 3: Бүртгэгдсэн зүйл, заалтын оновчтой, тодорхой байдал, ойлгомжтой эсэх зэргийг харгалзан 1-3 оноогоор үнэлсэн.

Алхам 4: Хэд хэдэн адил зүйл, заалтыг оноожуулан, судлаач бүр оноог жигд, оновчтой өгч байгаа эсэхийг хянаж баталгаажуулсан.

Үр дүн

Судалгааны ерөнхий мэдээлэл

ХБХ-ийн боловсрол эзэмшихтэй холбоотой харилцаанаас эрх зүйн зохицуулалт шаардлагатай гэж үзсэн харилцааг ялгаж хэд хэдэн шалгуураар шинжилсэн. Үүнд, ХБХ-ийг цэцэрлэг, сургуульд бэлтгэх, элсүүлэх бодлого, зохицуулалт (шалгуур 1), ХБХ суралцах, хөгжихөд шаардлагатай дэмжлэг, туслалцаа авах бодлого, зохицуулалт (шалгуур 2), ХБХ-ийн ахиц хөгжил, сурлагын амжилтыг үнэлэх бодлого, зохицуулалт (шалгуур 3), ХБХ-тэй ажиллах хүний нөөцийн бодлого, зохицуулалт (шалгуур 4), ХБХ-ийг боловсролд тэгш хамруулахад талуудын хүлээх үүрэг, хариуцлага (шалгуур 5), ХБХ-ийн талаар мэдээлэл цуглуулах, хуваалцах бодлого, зохицуулалт (шалгуур 6). Судалгааны арга зүй хэсэгт танилцуулсан алхмын дагуу шалгуур бүрийн дагуу шинжилгээ хийж, холбогдох зүйл, заалтыг илрүүлэн тоолж, оноо өгснийг дараах зургаас харж болно.




Зураг 2. Шалгуур бүрийн зүйл, заалт болон онооны тоо


Тухайлбал, Шалгуур 1-д хамаарах харилцааг зохицуулсан зүйл, хэсэг, заалт давхардсан тоогоор нийт 75 илэрсэн бол эдгээр зүйл, заалт хэр ойлгомжтой болон талуудын үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан эсэхийг нэгээс гурав хүртэлх оноогоор үнэлэхэд 77.5 оноо цуглуулсан нь бүртгэгдсэн зүйл, заалт тус бүр ойролцоогоор 1 оноог цуглуулсан юм. Энэ нь уг зүйл, заалтын зохицуулалт нь нийтлэг, ерөнхий шинжтэй, тодорхой бус, илүү нарийвчлах шаардлагатай байгааг харуулж байна.

Шалгуур бүрээр дээрх аргачлалыг ашиглан шинжилгээ хийсэн бөгөөд бид энэхүү өгүүллээр зөвхөн Шалгуур 2 буюу “ХБХ суралцах, хөгжихөд шаардлагатай дэмжлэг, туслалцаа авах бодлого, зохицуулалт”-ыг танилцуулж байгааг дахин сануулж байна. Уг зохицуулалттай холбоотой 16 хууль, захиргааны актад давхардсан тоогоор 182 зүйл, хэсэг, заалт илэрсэн. Шалгуурын хүрээнд нарийвчилсан шинжилгээ хийхдээ 1) шаардлагатай дэмжлэг, туслалцааг тодорхойлсон байдал, 2) төсөв, санхүүжилтийг тусгасан байдал, 3) хэрэгжилтийг хангах захиргааны акт батлагдсан эсэх болон 4) хуулийн этгээд, оролцогч талуудын эрх, үүрэгт тусгасан байдал гэсэн 4 дэд үзүүлэлтийг хэрэглэсэн.

Зураг 3-аас харахад ХБХ-дэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг тодорхойлсон зохицуулалт хамгийн их буюу 91 илэрсэн бол журам, захиргааны акт батлагдсан байдал нь хамгийн бага буюу 20 илэрсэн байна.



Зураг 3. Илэрсэн зүйл, заалтын тоо, цуглуулсан оноо



Зураг 3.1. Цуглуулах дээд оноо болон цуглуулсан оноо, хувь

Зураг 3.1-ээс үзэхэд дэд үзүүлэлт бүрээр илэрсэн, тухайн харилцааг зохицуулж буй зүйл, заалтууд нь тухайн харилцаанд оролцогчдын хувьд ойлгомжтой, тодорхой байх шаардлагыг зарим талаар хангахгүй байгаа нь харагдана. Өөрөөр хэлбэл, хэт ерөнхий, нарийвчилсан зохицуулалт хангалтгүй байна гэдэг дүгнэлт хийхүйц үр дүнтэй байна. Дэд үзүүлэлт бүрээр авч үзвэл:

1. Шаардлагатай дэмжлэг, туслалцааг тодорхойлсон байдал

ХБХ-ийг боловсролд тэгш хамруулах үүднээс төр, төрийн байгууллагаас тохирох дэмжлэг, туслалцааг зайлшгүй үзүүлэх шаардлагатай юм. Тэгш хамруулах зарчим гэдэгт ХБХ нь ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүй, чанартай албан боловсрол эзэмших болон амьдралаас суралцах үйл явцад хамрагдах, боловсролын шат түвшнээр ахиж дэвшихийг ойлгоно. Ялгаварлан гадуурхалтгүй байх эрхэд тусгаарлуулахгүй байх эрх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах эрх багтах төдийгүй төрийн хүртээмжтэй суралцах орчин, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах үүрэг ордог. (ХБХ-ий Эрхийн Зөвлөл, 2016)

Монгол Улс ХБХЭтХ-ийн 6 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах зарчмыг хуульчилсан. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглох ба түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ. ХБХЭтХ-д тусгагдсан ХБХ-ийг үл ялгаварлан гадуурхах зохицуулалт нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, түүний 4 дүгээр Ерөнхий зөвлөмжид зарчмын хувьд нийцнэ. ХБХЭтХ-ийн 14, 15 дугаар зүйлд ХБХ-ийн сурч боловсрох эрх, нөхцөлийг хуульчилж, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн хүлээх үүргийг зохицуулсан.

Энэхүү дэд үзүүлэлтийн үр дүнг сургалтын тохируулгат орчин, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын тохируулгат хөтөлбөр болон хүүхдийн хоол хүнс гэсэн агуулгаар авч үзлээ.

Сургалтын тохируулгат орчин

Сургалтын орчин гэдэг нь зөвхөн анги, танхимаар хязгаарлагдахгүй бөгөөд ариун цэврийн өрөө, хонгил, шат, зэрэг нь багтана. Түүнчлэн тохируулгат орчинд барилга байгууламж, явган хүний зам, замын болон дэд бүтцийн байгууламж нь ХБХ саадгүй хүрэх, чөлөөтэй нэвтрэх, ашиглах боломжтой байж, тэдний тусгай хэрэгцээ, шаардлагад нийцсэн байхыг ойлгоно.

ХБХЭтХ-д ХБХ-ийн бусад хүүхэдтэй хамт сурч, хөгжих эрхийг тусгасан нь ач холбогдол бүхий суурь зохицуулалт болжээ. ХБХЭтХ-ийн 9.5 дахь хэсгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцээгүй барилга байгууламжийг улсын комисс ашиглалтад хүлээн авахыг хориглосон нь шинээр баригдах болон одоо ашиглаж буй сургууль, цэцэрлэг, иргэний бүхий л барилга байгууламжийг ХБХ-ийн тусгай хэрэгцээнд нийцүүлэх, тэдний шаардлагыг хангахуйц болгоход баримтлах тодорхой зохицуулалт байна.

Шинжилгээнд авсан баримт бичгүүдэд бүх шатны боловсролын байгууллагад ХБХ сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэхийн тулд тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн сургалтын орчныг бүрдүүлэх арга хэмжээг төрөөс авч хэрэгжүүлэх ерөнхий зохицуулалт нийтлэг байна.

Сургалтын тохирох хэрэглэгдэхүүний тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод сургалтын орчныг бүрдүүлэх, сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангах нь ХБХ-ийг тэгш хамран сургах бодлого болохыг онцолсон. ХБХ-ийг тусгай сургуульд бус ердийн сургуульд суралцуулахаар болсон ч сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангаагүй бол тэгш хамран сургалт хэмээн үзэхгүй бөгөөд энэ нь тэднийг ялгаварлан гадуурхсан үйлдэл болно хэмээн дурдсан. Иймд ХБХ-ийг бүх шатны боловсролын байгууллагад тэгш хамран сургана гэдэг нь тэгш хамран сургах эрхийг хангахад шаардлагатай сургалтын тохируулгат орчныг бүрдүүлэх, сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангах явдал болно. Суралцагчдыг боловсролын тогтолцоонд тааруулахыг хичээхээс илүүтэйгээр хүн нэг бүрд таарсан хариу үйлдлийг боловсролын тогтолцоо үзүүлэх ёстой, оролцогч улсууд хувь хүнд үзүүлэх дэмжлэг, тохирох хэрэглэгдэхүүнийг чухалчлах,

заавал эзэмших боловсролын бүх шат түвшинд үнэ төлбөргүй олгохыг хүлээн зөвшөөрөх ёстой хэмээн уг конвенцод заасан.

ХБХЭтХ-д зааснаар бүх шатны сургалтын байгууллага нь ХБХ-ийг сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, тэдэнд амьдрах ухаан, мэргэжлийн ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх үүрэгтэй. Үүнд: хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах, сурах идэвх, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, онцлог хэрэгцээнд нийцүүлэн брайл үсэг, дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэхээр заажээ.

БтХ, СӨБтХ, БДБтХ-д сургалтын хэрэглэгдэхүүн нь зохих стандартад нийцсэн байна гэсэн суурь зохицуулалт тусгагдсан. “ХБХ-ийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах журам”, “ХБХ-ийг ЕБС-д тэгш хамруулах журам”, “ХБХ-дэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал”, “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам”, “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд байвал зохих хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслийн жагсаалт” болон сургалтын жишиг хөтөлбөрт сургалтын тохирох хэрэглэгдэхүүний талаар тусгасан гэж үзэж болно. Түүнчлэн, ЗГ-ын 2020 оны 235 дугаар тогтоолоор ХБХ-ийн СӨБ, бага, дунд боловсролын сургалтын тохирох хэрэглэгдэхүүний зардлыг төсөвт тусган санхүүжүүлэхийг холбогдох байгууллагад үүрэг болгожээ.

Харин зарим захиргааны актад сургалтын тохируулгат орчин, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бэлтгэхэд ХБХ-ийн эцэг эх, асран хамгаалагч, дэмжлэгийн багийг оролцуулахаар заасан зохицуулалтыг нягталж үзэх нь зүйтэй. (БСШУС, 2020)

Сургалтын тохируулгат хөтөлбөр

БСШУЯ-наас ХБХ-ийн сургалтын жишиг төлөвлөгөө, хөтөлбөртэй холбоотой хэд хэдэн аргачлал, хөтөлбөр төлөвлөгөөг батлан мөрдүүлж байна. Тухайлбал, “ХБХ-дэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал”, “ХБХ-ийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах журам”, “ХБХ-ийг ЕБС-д тэгш хамруулах журам”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлал” зэрэг байна. Эдгээрт хамран сургах тойргийн цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төв хариуцан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотой боловсруулж, хэрэгжүүлэх, сургууль нь хүүхдийн боловсролын ялгаатай хэрэгцээг тодорхойлж, дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулж хэрэгжүүлэхээр заажээ.

Эндээс үзэхэд ХБХ-ийг тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн орчныг бий болгоход хүчин чармайлт гаргасан гэж үзэхээр байгаа боловч сургалтын тохируулгат хөтөлбөртэй холбоотой зохицуулалт бүдэг, дийлэнх нь ГСТ-нд илүү төвлөрсөн байна. Тухайлбал,

- “ХБХ-ийг ЕБС-д тэгш хамруулах журам”-ын 4.1-д сургууль тэгш хамруулан сургах үйл ажиллагааг зохион байгуулахдаа ГСТ боловсруулан хэрэгжүүлнэ хэмээн заажээ.
- “ГСТ-ний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлал”-д сурагчийг хөгжлийн дөрвөн айгаар, дэмжлэгийн гурван орчинд хөгжүүлж, хүүхдэд бие даан амьдрах, нийгэмшихүйн чадвар олгохоор тусгасан.

Мөн танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хүүхдийг гэр бүлийн орчинд суурилан боловсролын үйлчилгээнд, СӨБ-ын хувилбарт сургалт, сургууль, насан туршийн бо

ловсролын явуулын багшийн үйлчилгээнд хамруулахаар зохицуулжээ. Хувилбарт сургалтад БШУЯ-наас баталсан хөтөлбөрийг баримтлах бөгөөд тухайн хүүхдийн онцлог хэрэгцээнд үндэслэн өөртөө үйлчлэх, амьдрах чадварт суралцах, энгийн чадвар дадал эзэмшүүлэх агуулгыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төлөвлөгөөний дагуу төлөвлөн эцэг, эх, асран хамгаалагчийн дэмжлэгтэй харьяа цэцэрлэг, сургууль хэрэгжүүлэх зохицуулалттай байна.

Хүснэгт 4. Сурагчийг хөгжлийн айгаар хөгжүүлэх урт хугацааны зорилтыг тодорхойлох аргачлалын жишээ

Хөгжлийн ай	Урт хугацааны зорилт	Дэмжлэгийн орчин		
		Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг	Засан сайжруулах үйл ажиллагааны дэмжлэг	Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг
Өөртөө үйлчлэх энгийн чадвар	Хувцасны шүүгээгээ олоод хувцсаа өөрөө хийх, авах	Хичээл эхлэхээс өмнө, хичээл дууссаны дараа		
Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	Үндсэн 3 өнгө, дугуй, дүрс ижлээр олох			Математик
Нийгэмшихүй	Сууж сургах, уух хэрэгцээг нь зурган карт ашиглан илэрхийлж сургах	Сургуульд ирэх, тарах үед, багштайгаа Найз нөхөдтэй уулзахдаа	Ахуй засал	Нийгэм ахуйн баримжаа
Бие бялдар хөдөлгөөн	Бөмбөг шидэх, товч товчлох			

БШУС-ын 2020 оны А/305 дугаар тушаалаар Хэл ярианы хөгжил жишиг хөтөлбөрийг, 2021 оны А/309 дүгээр тушаалаар Харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжаа олгох жишиг хөтөлбөр, “Харааны бэрхшээлтэй хүүхдэд орон зай, хөдөлгөөний баримжаа олгох жишиг хөтөлбөрийг тус тус баталжээ. Эдгээр нь хөгжлийн ялгаатай бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах тодорхой зохицуулалтыг агуулсан гэж үзэхээр байна. Тухайлбал, “Хэл ярианы хөгжил” жишиг хөтөлбөр нь хэл ярианы хөгжлийн сул талыг эрт илрүүлэх, сэргээн засах, хүүхдийн ярих, сонсох, унших, бичих чадварыг сайжруулахад чиглэгдсэн. Харааны бэрхшээлтэй хүүхдийн хувьд тэдэнд өөртөө үйлчлэх энгийн чадварыг хөгжүүлэх, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, танил биш орон зайд баримжаалах, дасан зохицох зэрэг арга барил, ур чадварыг эзэмшүүлэх, нийгмийн амьдралд бие даан оролцоход нь бэлдэхдээ тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр байна.

Сургалтын хөтөлбөр, тэр дотроо сургалтын тохируулгат хөтөлбөртэй холбоотой зохицуулалтын хүрээнд дараах анхаарах зүйлс байна гэж үзлээ. Үүнд:

- Тэгш хамруулан сургах үйл ажиллагааг зөвхөн ГСТ-ээр, агуулгыг зөвхөн тухайн батлагдсан аргачлалд заасан хөгжлийн айгаар хязгаарлах эрсдэл байна гэж үзэхээр байна. ХБХ-үүд ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрхэн судлах, тэдний академик ур чадвар болон сургалтын хөтөлбөрт заасан чадвар, үнэт зүйлсийг хэрхэн хөгжүүлэх талаарх зохицуулалт хомс байна. Энд судалгааны хүрээнд мэдээлэл цуглуулахад оролцсон

экспертүүд “ГСТ-г боловсруулах аргачлал, загварт сурагчдад академик мэдлэг олгох арга зүй, жишээг нэмэлтээр оруулах шаардлагатай” гэж үзсэнийг тэмдэглэж байна.

- Хувилбарт сургалт болон явуулын багшийн зохицуулалтыг тусгасан нь ХБХ-ийн онцгой хэрэгцээ, орчин нөхцөлийг харгалзан үзсэн давуу талтай боловч дэлхий нийтийн чиг хандлага нь аль болох тусгаарласан нөхцөл байдлаас татгалзаж, илүү интеграцчилсан, тэгш хамруулсан хандлагыг баримтлах болсныг БХШДТ-аас харж болно.

“2020-2024 онд хэрэгжүүлэх ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.12-г цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулах бодлого баримтлахаар тусгасан нь анхаарал татаж байна. Энэ нь цахим сургалтын хөтөлбөрийг ХБХ-ийн онцлогт нийцүүлэн боловсруулах, тохируулгат хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгох, бэлтгэх, нийлүүлэх шинэ хэрэгцээ үүснэ гэсэн үг бөгөөд үүнтэй холбогдож үүсэх харилцааг мөн зохицуулах хэрэгцээ үүсэхийг анхаарах хэрэгтэй юм.

Хүүхдийн хоол хүнс

Таван жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт цэцэрлэг, дотуур байр, ЕБС-ийн хүүхдийн хоолны зардлыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан хоёроос доошгүй дахин нэмэгдүүлж, ЕБС-ийн “Үдийн цай” арга хэмжээг “Үдийн хоол” болгох, ЕБС-ийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангах зорилт тавьсан. ХБХЭТХ-д ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцагчийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан. 2019.05.30-ны өдөр ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль батлагдсанаар ЕБС-д суралцаж байгаа болон дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн хоолны үйлчилгээнд суралцагчийг тэгш хамруулахаар болсон. ЗГ-ын 2021 оны 237 дугаар тогтоолоор ЕБС-ийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлыг 1-5, 6-9 дүгээр ангиар ялгаатай тогтоосон байна.

СӨБ-ын хувьд СӨБТХ-д зааснаар төр болон эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийн хоолны зардлын тодорхой хувийг хамтран хариуцдаг бол ХБХ-ийн хувьд улсын төсвөөс хариуцах зохицуулалт байна. ЗГ-ын 2019 оны 450 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг тухайн цэцэрлэгийн ажиллах цагаас хамаарч ялгаатай тогтоосон зохицуулалт хийжээ.

Эдгээр зохицуулалтаас харахад ЕБС-д суралцагчийг үдийн цай, үдийн хоолоор хангахтай холбоотой үйл ажиллагааны зохицуулалт харьцангуй ойлгомжтой, тодорхой байна гэж үзэх үндэстэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших эрх зүйн орчинд хийсэн шинжилгээний Шалгуур 2-ын “Шаардлагатай дэмжлэг, туслалцааг тодорхойлсон байдал” гэх дэд үзүүлэлтийн хүрээнд хамгийн олон зүйл, заалт бүртгэгдсэн боловч хамгийн бага оноогоор үнэлэгдсэн байна. Энэ нь ХБХ-дэд зориулсан сургалтын тохируулгат орчныг бүрдүүлэх, сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар хуулийн ерөнхий зүйл заалтууд байгаа боловч тухайн чиглэлээр үүсэж буй харилцааг зохицуулахад илүү ойлгомжтой, тодорхой байх шаардлагыг хангахгүй байгааг харуулж байна. Ялангуяа, сургалтын тохируулгат хөтөлбөрийн тухайд зохицуулалт туйлын бүдэг байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна.

2. Төсөв, санхүүжилтийг тусгасан байдал

Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгох бөгөөд БТХ-д зааснаар ерөнхий боловсролд бага, суурь, бүрэн дунд боловсролыг хамруулдаг. БТХ-ийн 43.2.7-д хөгжлийн

бэрхшээлтэй суралцагчийг сурах нөхцөл бололцоогоор төрөөс хангах, ХБХЭтХ-ийн 14.1.3-т төрөөс бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлнэ гэж хуульчилсан.

ХБХЭтХ-ийн 15.7, 15.11, 15.12-т ХБХ-ийн сурч боловсроход гарах зардал, санхүүжилтийн талаар дараах зохицуулалт тусгагдсан:

- ЕБС-д суралцаж байгаа ХБХ-ийн онцлог хэрэгцээнд нийцсэн ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авах зардлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн тухайн жилийн төсөвт тусгана;
- ХБХ-ийн сургалтын онцлог хэрэгцээг хангах сургалтын хөтөлбөр, ном, сурах бичиг, гарын авлага, дохионы хэлний толь бичиг зохиох, хэвлэх, түгээх, засан сайжруулах, брайль болон программ хангамжийг Монгол хэл рүү хөрвүүлэх, сургалтын тоног төхөөрөмжийг худалдан авах болон шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна;
- ЕБС-ийн суралцагчийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

СӨБтХ-д хүүхдийн хичээлийн хэрэглэл, ариун цэврийн зардлыг эцэг, эх нь, ХБХ-ийн хоолны болон норматив зардлыг төрөөс хариуцахаар заасан. “ХБХ-ийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах журам”-д ХБХ-ийн хувьсах зардлыг нэмэгдүүлж тооцох, багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох, шаардагдах хөрөнгийг хандив, тусламжаар шийдвэрлэж болно хэмээн тусгажээ. “ХБХ-ийг ЕБС-д тэгш хамран сургах журам”-аар ХБХ-ийн хувьсах зардлыг ЗГ-аас баталсан журмын дагуу нэг суралцагчийн хувьсах зардлын нормативыг гурав дахин нэмэгдүүлж тооцно, сурах бичиг, гарын авлага, сургалтын тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүн худалдан авах, сургууль, анги танхим тохижуулахад шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрөөр шийдвэрлэнэ гэжээ.

ЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүнийг дараах гурван зардлаас бүрдэхээр тогтоосон байна. Үүнд, 1)багш, хүүхдийн цэцэрлэг, дотуур байрны багш, ажилтны албан тушаалын цалин болон нэмэгдэл цалин, зарим нэмэгдэл; 2)багшийн үндсэн болон нэмэгдэл цалинд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл; 3)бараа, үйлчилгээний бусад хувьсах зардал. Бараа, үйлчилгээний бусад хувьсах зардалд нь хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх, бичиг хэрэг, ном, хэвлэл, шуудан холбоо, интернэтийн төлбөр, дотоод албан томилолт, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс, нормын хувцас, зөөлөн эдлэл, эм бэлдмэл, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчийн устгал, ариутгал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж багтдаг байна. Эндээс үзэхэд сургалтын тохируулгат орчин бүрдүүлэх, сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангах зэрэг зардал нь нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд багтдаггүй байна.

“ХБХ-ийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах журам”, “ХБХ-ийг ЕБС-д тэгш хамран сургах журам”-д тусгагдсан санхүүжилттэй холбоотой заалтыг харьцуулж үзэхэд хувьсах зардлыг нэмэгдүүлж тооцох хэмжээ болон сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангахтай холбоотой санхүүжилтийн эх үүсвэрийг ялгаатай тогтоосон байна.

“Төсөв, санхүүжилтийг тусгасан байдал” гэх дэд үзүүлэлтийн хүрээнд бүртгэгдсэн зүйл, заалтууд бусад дэд үзүүлэлтийн хүрээнд бүртгэгдсэн зүйл, заалтаас харьцангуй оновчтой, ойлгомжтой байна гэж үзэхээр байна. Цаашид ХБХ цэцэрлэгт хамрагдахад хүүхдийн хувьсах зардлыг ямар хэмжээгээр нэмэгдүүлэн тооцохыг ЕБС-ийн суралцагчийнхтай адил тодорхой болгох, сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт улсын төсвийг нэмж тусгах нь зүйтэй юм.

Хүснэгт 5. Зардал тооцох журам

Зардлын төрөл	Захиргааны акт (журам)		Тайлбар	Хууль зүйн үндэслэл
	“ХБХ-ийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах журам”	ЕБС-д тэгш хамран сургах журам”		
Суралцагчийн хувьсах зардал	Нэмэгдүүлж тооцно.	3 дахин нэмэгдүүлж тооцно.	Цэцэрлэгийн суралцагч ХБХ-ийн хувьсах зардлыг ямар хэмжээгээр нэмэгдүүлж тооцохыг тодорхой болгох шаардлагатай.	Захиргааны ерөнхий хуульд тусгагдсан захиргааны актын ойлгомжтой, тодорхой байх шаардлага.
Ном, тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн зардал	-Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр; -Хандив, тусламж	-Улсын төсөв; -Гадаад, дотоодын төсөл хөтөлбөр	Цэцэрлэгийн суралцагч ХБХ-ийн тохирох хэрэглэгдэхүүний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн хүрээ хязгаарлагдмал байна.	ХБХЭТХ-ийн 14.1.3, СӨБГХ-ийн 15.1-д заасны дагуу улсын төсөвт тусган шийдвэрлэж болно.

3. Журам, захиргааны акт батлагдсан байдал

Энэхүү шинжилгээгээр ХБХ суралцах, хөгжихөд шаардлагатай дэмжлэг, туслалцааг зохицуулах журам, захиргааны акт батлагдсан байдал нь хамгийн бага буюу 20 зохицуулалттай, мөн хамгийн бага буюу 5.5 оноо авсан нь хангалтгүй үнэлгээ болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу бүх нийтээр дагаж мөрдүүлэх хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зөвхөн УИХ-ын онцгой бүрэн эрх юм. Иймд нийтээр заавал дагаж мөрдүүлэх шинжтэй, нийгмийн тодорхой харилцааг дахин давтан зохицуулсан хэм хэмжээ тогтоох нь УИХ-ын онцгой бүрэн эрхэд хамаарах тул УИХ өөрийн онцгой бүрэн эрхээ хууль батлах замаар төрийн эрх бүхий байгууллага, зохих этгээдэд шилжүүлдэг. Үүнийг Захиргааны ерөнхий хуульд захиргааны үйл ажиллагаа хуульд үндэслэх хэмээн тусгасан бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтны бүхий л үйл ажиллагаа гагцхүү хуульд нийцсэн байх ёстой. Хуульд тусгаагүй, хуулиар зохицуулаагүй гэдэг шалтгаар аливаа асуудлыг шийдвэрлэх нь “дур зоргоор” явдал болох бөгөөд хуульд үндэслэх, хууль дээдлэх зарчмыг зөрчсөн явдал болно. Нийтийн, төрийн, захиргааны албан тушаалтны бүх үйлдэл, үйл ажиллагаа зөвхөн хуульд заасны дагуу явагдах, хуулиар зөвшөөрсөн зүйлийг зөвшөөрсөн хүрээ хязгаарын дотор гүйцэтгэх, иргэн хүн хуулиар хориглоогүй бүхнийг гүйцэтгэх эрхтэй болно. Энэ зарчмыг товчоор нийтийн албан тушаалтанд “хуулиар зөвшөөрөгдөөгүй бүхэн хориглогдоно”, иргэнд “хуулиар хориглогдоогүй бүхэн зөвшөөрөгдөнө” гэж үздэг.

Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага, албан тушаалтнаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга

давтагдах шийдвэрийг хэлдэг. Захиргааны ерөнхий хуулийн 59.1, 60.1.2, 64.1-д захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах үндэслэл, шаардлагыг тодорхойлсон бөгөөд “хуулиар тусгайлан эрх олгосон байх” нь захиргааны актад тавигдах хамгийн чухал шаардлага болно. ХБХЭтХ, Боловсролын хууль тогтоомж, Нийгмийн халамжийн тухай хуулийн захиргааны акт батлан гаргах эрх олгосон зохицуулалтыг судалж, үүний дараа эдгээр зохицуулалтаас ХБХ-ийн сурч боловсрох эрхэд хамаарах захиргааны акт батлах зохицуулалтад шинжилгээ хийсэн. ХБХ-ийн сурч боловсрох эрхэд хамаарах ХБХЭтХ-д 10, БтХ-д 2, СӨБтХ-д 3, БДБтХ-д 4, Нийгмийн халамжийн тухай хуульд 1, нийт 20 захиргааны акт батлах зохицуулалт тусгагджээ.

Хүснэгт 6. Захиргааны актын батлагдсан байдал

Баримт бичиг	Дугаар	Хууль зүйн үндэслэл	Батлах субъект	Батлагдсан эсэх
ХБХЭтХ	1.	12.2	БШУЯ, ХНХЯ	-
	2.	13.2	БШУЯ санал, СХЗГ	+
	3.	15.2	БШУЯ	+
	4.	15.3	БШУЯ	+
	5.	15.6, 15.8	ЗГ	-
	6.	15.9	БШУЯ, ХНХЯ	-
	7.	15.10	ЗД	
	8.	15.12	БШУЯ	
	9.	37.5	ЗГ	+
	10.	37.6	ЭМС, БШУС, ХНХС	+
БтХ	11.	39.7,	ЗГ	+
	12.	40.5	БШУС	+
СӨБтХ	13.	8.6	БШУЯ, ЭМЯ, ХНХЯ	-
	14.	8.15	БШУЯ, ЭМЯ, ХНХЯ	-
	15.	9.14	БШУЯ, ЭМЯ, ХНХЯ	-
БДБтХ	16.	12.9	БШУЯ, ЭМЯ	-
	17.	13.2	БШУЯ	-
	18.	13.8	БШУЯ, ЭМЯ, ХНХЯ	-
	19.	13.9	БШУЯ	+
НХтХ	20.	20.1.1, 20.2.2, 20.5	ХНХЯ, БШУЯ	+

Эдгээр 20 захиргааны актаас дараах 9 акт нь шинжилгээ хийх үед хараахан батлагдаагүй байна.

- “Тусгай, гэр цэцэрлэг болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, эрүүл ахуй, ариун цэврийн дүрэм”, “Асрамжийн болон халамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”;
- “Сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байгууллагын нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо”;
- “Тусгай цэцэрлэгт ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо”;
- “Ерөнхий боловсролын сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүний насны зөрүү”;
- “Ерөнхий боловсролын тусгай сургуулийн хамран сургах тойрог тогтоох, аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар бүлэг ажиллуулах, элсэлтийг зохион байгуулах журам”;

- “Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо;
- “Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журам”;
- “Энэ хуулийн 15.6-д заасан сургалтын зардлын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.”;
- “Ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт, зардлын хэмжээ, олгох журам”.

Эдгээрээс цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, хамран сургах тойрог тогтоох, салбар бүлэг ажиллуулах, Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ, тусгай хэрэглээний жагсаалт, зардлын хэмжээ, олгох харилцааг зохицуулсан захиргааны актыг ХБХЭТХ, Боловсролын хууль тогтоомжид нийцүүлэн батлах шаардлагатай хэмээн үзнэ. Харин нэг багшид ногдох ХБХ-ийн тоо, насны зөрүүний асуудлыг олон улсын жишиг туршлагыг судлан, олон улсын конвенцод нийцүүлэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх нь зүйтэй.

Түүнчлэн дээр дурдсан хуульд хийсэн шинжилгээгээр захиргааны акт батлах эрхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгосон зохицуулалт илрээгүй боловч зарим захиргааны актыг БШУЯ-наас батлан мөрдүүлж байна. Тухайлбал: “ХБХ-ийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах журам”, “ХБХ-ийг ЕБС-д тэгш хамран сургах журам”, “ЕБС-ийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл” зэрэг болно.

Журам, захиргааны акт батлагдсан байдлын шинжилгээнээс үзэхэд БШУЯ-наас ХБХ-ийг тэгш хамран сургах талаар тодорхой арга хэмжээ авч байгаа нь сайшаалтай боловч бусад төрийн захиргааны төв байгууллагатай энэ талаар хамтран ажиллах асуудал хангалтгүй гэж үзэхээр байгааг хамтран баталж мөрдүүлэхээр хуульд заасан захиргааны актууд батлагдаагүй байгаагаас харж болохоор байна. ХБХ-ийг тэгш хамран сургах боловсролын тогтолцоонд хамруулахаар батлан мөрдүүлж байгаа зарим захиргааны акт нь “хуулиар тусгайлан эрх олгогдсон байх” шаардлагад нийцэхгүй байгаад дүгнэлт хийж, зохих арга хэмжээ авах нь зүйтэй байна.

4. Талуудын үүрэг хариуцлага

ХБХ суралцах, хөгжихөд шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлэхэд талуудын эрх, үүргийг тодорхойлсон 46 заалт (давхардсан тоогоор) шинжилгээгээр илэрсэн. “ХБХ-дэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал”, “ХБХ-ийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс” болон бусад журмаар Төв болон салбар комисс, хамран сургах тойргийн цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төв, дэмжлэгийн баг, БХДЗ, Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, эцэг эх, асран хамгаалагчийн хүлээх эрх, үүргийг тодорхой зохицуулжээ.

ХБХ-ийн боловсрол эзэмших харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”, “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” эсхүл, “Энэ хуулийг зөрчсөн этгээдийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Эрүүгийн

хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ” гэсэн зохицуулалт нийтлэг байна.

Зөрчлийн тухай хуульд БтХ, БДБтХ-ийг зөрчсөн этгээдэд ногдуулах хариуцлагыг заасан. Боловсролын стандарт, эсхүл сургалтын байгууллагад тавигдах шаардлагыг зөрчсөн; бага, дунд боловсролын сурах бичгийн боловсролын стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангуулаагүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

“Талуудын үүрэг хариуцлага” гэх дэд үзүүлэлтийн хүрээнд бүртгэгдсэн зүйл, заалтууд бусад дэд үзүүлэлтийн хүрээнд бүртгэгдсэн зүйл, заалтаас харьцангуй ойлгомжтой, тодорхой байна гэж үзэхээр байна. Гэвч үүрэг, хариуцлагын тухайд багш голлон үүрэг гүйцэтгэхээр зохицуулагдсан байгааг анхаарч цаашид сургуулийн Дэмжлэгийн баг, бусад субъект болох нийгмийн ажилтан, сургуулийн эмч, сургуулийн удирдлага, эцэг эх зэрэг оролцогчийг чадваржсан байх шаардлагыг хууль тогтоомжоор үүрэг болгох боломжтой байна. Мөн СӨБтХ зөрчихөд хүлээлгэх хариуцлагыг уг хуульд заагаагүй байгааг анхаарах нь зүйтэй.

Хэлэлцүүлэг

ХБХ сурч, хөгжихөд шаардлагатай дэмжлэг, туслалцааны бодлого, зохицуулалтыг дөрвөн үзүүлэлтээр шинжилж үзэхэд бодлогын баримт бичиг, хууль, захиргааны актад ХБХ-дэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг тодорхой хэмжээгээр, тэдгээр дэмжлэг, туслалцааг үзүүлэх талаар талуудын эрх, үүрэгт мөн зохих хэмжээгээр тусгажээ гэж үзэхээр байна. Гэвч бүртгэсэн зүйл, заалтын хүрээнд цуглуулсан онооноос үзэхэд эдгээрийн ихэнх нь ерөнхий, нийтлэг шинжтэй, холбогдох эрх зүйн актад тодорхойлсон шаардлагыг тэр болгон хангахгүй байгааг анхаарах шаардлага байна.

ХБХ-ийн боловсрол эзэмших эрхийг хангах, хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг цаашид сайжруулахад анхаарч, тодорхой зүйл, заалтууд байна. Үүнд:

- ХБХ-дэд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх төсөв, санхүүжилтийн зохицуулалт нь төр хариуцах гэсэн нийтлэг заалттай хэдий ч нарийвчилсан хэм хэмжээ болох захиргааны актын зохицуулалт нь зөрүүтэй, ойлгомжгүй болжээ.
- Боловсролын хууль тогтоомжид тусгагдсан боловсролын харилцаанд дагаж мөрдүүлбэл зохих захиргааны актын ихэнх буюу 55 хувийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан батлан гаргасан боловч ХБХ-ийн сурч боловсрох харилцаанд хамаарах захиргааны актын батлагдсан байдал хангалттай бус байна.
- МУ-ын урт хугацааны бодлогын баримт бичиг, 2020-2024 оны ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн ХБХ-ийг ЕБС-д тэгш хамран сургах журам мөрдөгдөж байгаа боловч зөвхөн ГСТ-гөөр хязгаарлагдах эрсдэл байна. Ялангуяа, сургалтын тохируулгат хөтөлбөрийн тухайд зохицуулалт туйлын бүдэг байгаад анхаарал хандуулах шаардлагатай.
- Төсөв санхүүжилттэй холбоотой захиргааны актад зарим зардал, төсвийг ялгаатай байдлаар тусгасан, ХБХ-дэд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх зардлыг орон нутгийн төсөвт хэрхэн тусгах нь тодорхой бус байна.
- ХБХ-ийн боловсрол эзэмших эрхийг хангах, хамгаалахтай холбоотой хуулиар заасан дүрэм, журмыг цаг тухайд нь, гүйцэд баталж мөрдүүлэх тал дээр учир дутагдалтай байх бөгөөд энэ чиглэлээр холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сул байгаа нь шинжилгээнээс харагдлаа.

- Үүрэг, хариуцлагын тухайд багш голлон үүрэг гүйцэтгэхээр зохицуулагдсан байгааг анхаарч цаашид сургуулийн Дэмжлэгийн баг, бусад субъект болох нийгмийн ажилтан, сургуулийн эмч, сургуулийн удирдлага, эцэг эх зэрэг оролцогчийг чадваржсан байх шаардлагыг хууль тогтоомжоор үүрэг болгох боломжтой байна.

Дүгнэлт

ХБХ-ийн боловсрол эзэмших эрхийг хангах, хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын судалгааны хүрээнд “ХБХ суралцах, хөгжихөд шаардлагатай дэмжлэг, туслалцаа авах бодлого, зохицуулалт” гэх шалгуураар шинжилгээ хийхэд уг зохицуулалттай холбоотой 16 хууль, захиргааны актад давхардсан тоогоор 182 зүйл, хэсэг, заалт илэрлээ. Шинжилгээний дүнгээс үзэхэд Монгол Улсын урт болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон холбогдох хууль тогтоомжид ХБХ суралцах, хөгжихөд шаардлагатай дэмжлэг, туслалцаа авахтай холбоотой нийтлэг, ерөнхий заалтуудыг тусгасан гэж үзлээ. Тухайлбал, ХБХ-ийн боловсрол эзэмших эрх, орчин нөхцөлийг хангах, сургалтын тохируулгат орчин, сургалтын тохирох хэрэглэгдэхүүний талаар ХБХЭТХ-д тусгагдсан зохицуулалт ойлгомжтой, тодорхой байгаа бол боловсролын хууль тогтоомжид сургуулийн барилга байгууламж, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж нь зохих стандартын шаардлагыг хангасан байна гэсэн нийтлэг зохицуулалт тусгагдсан байна.

Шинжилгээ бүхэлдээ “ХБХ суралцах, хөгжихөд шаардлагатай дэмжлэг, туслалцаа авах бодлого, зохицуулалт”-тай холбоотой зүйл заалтууд нь хэт ерөнхий, нийтлэг шинжтэй байгааг харуулсан гэж бид үзлээ. Мөн зарим хууль болон захиргааны актад тэгш хамран сургах үзэл санаатай нийцээгүй, ХБХ-ийг ялгаварласан байж болох магадлалтай зохицуулалт байгааг бид анзаарсан бөгөөд энэ нь ялангуяа, ХБХ-ийн судлах сургалтын хөтөлбөрт тохируулга хийхтэй холбоотой байгааг тэмдэглэж байна.

Энэхүү шинжилгээний үр дүн нь цаашид энэ салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль тогтоомжийг эрх зүйн актад тавих шаардлагыг хангахуйц байхаар боловсруулахад анхаарах асуудлыг илрүүлснээрээ ач холбогдолтой юм.

Ном зүй

АХБ. (2020). Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь судалгааны тайлан.

БНБЭ. (2021). Монгол Улсын тэгш хамруулах боловсролын бодлого болон үйл ажиллагаанд хийх .

БСШУС. (2020). ЕБС-ийн хүүхдийн хөгжлийн дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл.

НҮБ. (2018). НҮБ-ын Хүүхдийн сангийн 2012-2016 ба 2017-2021 оны улс орны хөтөлбөрийн хүрээн дэх тэгш хамруулсан суурь боловсролын үнэлгээ.

ХБХ-ий Эрхийн Зөвлөл. (2016). ХБХ-ийн боловсролд тэгш хамрагдах эрхийн тухай 4-р Ерөнхий Зөвлөмж. <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G16/263/00/PDF/G1626300.pdf?OpenElement>-ээс гаргасан

ЮНЕСКО. (2019). Educational content up close: examining the learning dimensions of Education for Sustainable Development and Global Citizenship Education.

<https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000372327>-ээс гаргасан.

ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ СУРГУУЛИУДЫН ХЯНАЛТЫН ИНТЕРАКТИВ ТОГТОЛЦООНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

COMPARATIVE STUDY OF PUBLIC UNIVERSITIES' INTERACTIVE CONTROL SYSTEM

Д.Баярмаа
Dashjamts Bayarmaa

ШУТИС, Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн сургууль

bayamad@must.edu.mn

Хураангуй

Хэмжигч чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй. Төрийн өмчийн их сургууль бизнесийн байгууллагын нэгэн адил төлөвлөснөө гүйцэтгэж, гүйцэтгэлээ хянаж сайжруулж чадсан цагт хөгжиж дэвшинэ. Сургалт, эрдэм шинжилгээ судалгааны байгууллага болох их сургуульд хяналтыг гагцхүү дээрээс доошоо чиглэлд шийдвэр гаргадаг бюрократ бүтцийн хүрээнд дүрэм журмаар хангах боломжгүй. Их сургуулийн удирдлагын үйл явцад багш ажилтан нарын оролцоог хангасан интерактив хяналтын тогтолцоог уламжлалт бюрократ хяналтын тогтолцоотой хамтад нь хэрэгжүүлэх нь илүү оновчтой хувилбар юм. Энэхүү өгүүлэлд төрийн өмчийн 6 их сургууль болох МУИС, ШУТИС, АШУҮИС, ХААИС, МУБИС ба СУИС-ийн хяналтын тогтолцоог сургууль тус бүрийн хэрэгжиж буй дүрэм, журамд удирдлагын бүтцийг тусгасан байдлаар, харин санхүүгийн үзүүлэлтүүдийг аудитын тайлангийн үр дүнгээр харьцуулан судлав. Судалгааны үр дүнд эрдмийн ба удирдах зөвлөл дэх багш нарын төлөөллийг, удирдлагаа нууц санал хуралтаар сонгох боломжийг олгосноор хяналтын интерактив тогтолцоог бүрдүүлж чадсан МУИС нь санхүүгийн үр дүнгээр харьцангуй сайн байгаа нь тогтоогдов.

Түлхүүр үг: *их сургуулийн дүрэм, удирдлагын бүтэц, аудитын тайлан, хяналтын тогтолцоо, санхүүгийн үр дүн*

Abstract

You can't manage what you can't control, you can't control what you can't measure. Like in any other business organization, management of a university requires planning, execution, control, and improvement. In a university, where educational and research activities are

thriving, control administered solely by rules and regulations through a top-down bureaucratic structure is insufficient. An interactive control system, which ensures the participation of faculty and staff in the university management process, accompanying the traditional bureaucratic control system appears to be the more optimal solution. This paper examines the control system defined in university rules and regulations, and compares financial performance reported in audits of the following six public universities: the National University of Mongolia, Mongolian University of Science and Technology, Mongolian National University of Medical Sciences, Mongolian University of Life Sciences, Mongolian State University of Education, and Mongolian State University of Art and Culture. As a result of the research, it was found that the National University of Mongolia, which had established an interactive system of control by allowing the representatives of faculty in the academic and governing councils and the leadership to be elected by secret ballot, is doing relatively well in terms of financial results.

Keywords: *university rules and regulations, organizational structure, audit report, control system, financial results*

Удиртгал

Боловсролын салбар өнөөдөр ямар байгаагаас улсын хөгжил ирээдүйд ямар байх нь шалтгаална. Иймээс боловсролын салбарын шинэчлэлийн суурь зөв тавигдвал улс орон хөгжин дэвшинэ, суурь муу бол уналт доройтол нүүрлэнэ. Дээд боловсролын салбарт төрийн өмчийн 6 их сургууль болох МУИС, ШУТИС, АШУҮИС, ХААИС, МУБИС ба СУИС нь чанартай боловсролыг хүртээмжтэй хүргэхэд томоохон хувь нэмрийг оруулдаг. Дээд боловсролын салбар нь зах зээлийн эдийн засагт шилжээд байгаа Монгол улсад төдийгүй дэлхий дахинд шинэчлэл хийгдэж буй салбар юм. Дэлхий нийтэд ажиглагдаж буй боловсролын салбарын шинэчлэл дараах чиглэлд явагдаж байна. Үүнд:

- Хараат бус, бие даасан байдлыг хангах
- Хяналт ба менежментийн тогтолцоонд төрийн оролцоо нөлөөллийг багасгаж хариуцлагатай болгож бие даалгуулах
- Санхүүгийн хяналт зэргийг хөндлөнгийн агентлагуудад хариуцуулах (жишээлбэл Үндэсний аудитын газар)
- Орлогын шинэ эх үүсвэрүүдийг бий болгох боломжийг олгох
- Сургалтын чанарт хөндлөнгийн үнэлгээ хийх (жишээлбэл Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл)
- Захирал, удирдах зөвлөлийн дарга ба гишүүдийн томилгоог төр хийдгийг болиулах
- Захирал ба зөвлөлд менежментийн ур чадвартай байх шаардлагыг тавих зэрэг хандлагууд ажиглагдаж байна [1].

1. Байгууллагын удирдлагын бүтэц ба менежментийн хяналтын тогтолцоо

Байгууллага тавьсан зорилго зорилтууддаа хүрэх эсэх нь тухайн байгууллагын удирдлагын бүтэц ямар байгаагаас ихээхэн шалтгаална. Өөрөөр хэлбэл удирдлагын бүтэц нь тухайн байгууллага тавьсан зорилгодоо хүрэхэд тушаа саад болохгүйгээр онцлог шинж чанар, орчинд нь нийцсэн байх шаардлагатай.

Менежмент нь төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт ба сайжруулалт гэсэн 4 алхмаас тогтох тасралтгүй үйл явц бөгөөд төлөвлөснөө гүйцэтгэснээр оршин тогтнох, хянаж сайжруулснаар байгууллага хөгжин дэвших нөхцөл бүрдэнэ. Төлөвлөлт ба хяналт нь нэг тэрэгний хоёр дугуй мэт. Төлөвлөөгүй зүйлээ хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол төлөвлөгөө биелэхгүй. [2]. Хяналтыг байгууллагад шууд үнэлгээ, эргэх холбоо, нийгмийн ба соёлын зэрэг олон янзын хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой. Менежментийн хяналт нь байгууллага доторх мэдээллийн урсгал, мэдээлэл боловсруулж хүргэх үйл явцтай уялдаа холбоотой байдаг. Бизнесийн стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд байгууллагын үнэт зүйлс (core values), зайлсхийх хэрэгтэй эрсдэлүүд (risks to be avoided), гүйцэтгэлийн үнэлгээний үзүүлэлтүүд (critical performance variables), стратегийг хэрэгжүүлэх явцад үүсэж болох тодорхой бус нөхцөл байдал (strategic uncertainties) гэсэн 4 зүйлийг анхааралд авч шинжлэх хэрэгтэй болдог. Менежментийн хяналтын тогтолцоо нь үнэт зүйлс дээр суурилах итгэл үнэмшлийн тогтолцоо (belief systems), зайлсхийх ёстой эрсдэлүүдийг тусгасан дүрэм журмын тогтолцоо (boundary systems), гүйцэтгэлийн үнэлгээний үзүүлэлтээр хэмжигдэх хяналтын оношилгооны тогтолцоо (diagnostic control systems), стратегийг хэрэгжүүлэх явцад үүсэж болох тодорхой бус нөхцөл байдалд шийдэл эрэлхийлэх оролцоонд тулгуурласан хяналтын интерактив тогтолцоо (interactive control systems) гэсэн хоорондоо уялдаа холбоотой 4 дөрвөн тулгуур баганатай [3].

Итгэл үнэмшлийн ба хяналтын интерактив тогтолцоо нь стратегийг хэрэгжүүлэхэд сэдэлжүүлэх, урам зориг өгөх, бүтээлч шийдлийн хүч бол дүрэм журам ба хяналтын оношилгооны тогтолцоо нь хил хязгаарыг тогтоох, нийцүүлж мөрдүүлэх хүчийг илтгэнэ.

Хүснэгт 1. Стратегийн хэрэгжилтийн хяналтын тогтолцооны 4 тулгуур (Simons, 1994)

Хяналтын хэлбэр	Албан		Албан бус	
	Зохицуулалтын	Оношилгооны	Итгэл үнэмшлийн	Интерактив
Хэрэгсэл	Дүрэм журам	Гүйцэтгэлийн тоон үзүүлэлтүүд	Үнэт зүйлс	Оролцоо, идэвх
Үр дүн	Эрсдэлээс зайлсхийх	Хэмжилт, оношилгоо	Итгэл үнэмшил бүрдүүлэх	Ажиллагчдын шийдвэр гаргалтад оролцоо

Арга билиг хослуулахтай нэгэн адил хяналтын тогтолцоо нь албан ба албан бус хэлбэрийн аль алиныг нь хослуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, стратеги нь соёлын нэгэн адил байгууллагын гишүүн бүрийн санаархал, үйлдэлд нэвт шингэсэн хамтын үзэл бодол ба зан үйлээр илэрч хэрэгжинэ, хэрэгжилт нь харин хянагдах ёстой. Стратегийн хэрэгжилтийг энэ өнцгөөс дүрэм журам, гүйцэтгэлийн үр дүнгээр хянахын зэрэгцээ итгэл үнэмшил төрүүлж ба интерактив харилцааг бүрдүүлснээр хянах боломжтой.

2. Судалгааны арга зүй ба өгөгдөл

Энэхүү өгүүлэлд төрийн өмчийн 6 их сургуулийн хяналтын тогтолцоог Симонсын тодорхойлсон 4 тулгуур хэмжээсээр судлав. Үүнд:

1. *Итгэл үнэмшлийн тогтолцоо.* Байгууллагын үнэт зүйлс нь байгууллагын соёлын ундарга болж, баримтлах стратегийн хэрэгжилтийн үндэс суурийг бүрдүүлдэг ба хэрэгжилтэд албан бус хяналтын үүргийг гүйцэтгэдэг байна. Менежментийн үйл ажиллагаа үр дүнтэй байхын тулд итгэл үнэмшлийн тогтолцоо нь тул дүрэм журмын тогтолцоотойгоо уялдаатай байх шаардлагатай. Итгэл үнэмшлийн тогтолцоог их сургуулийн томьёолсон алсын хараа, үнэт зүйлс ба эрхэм зорилгын хүрээнд албан ёсны вэбсайтад дээрээ тавьсан мэдээллийн хүрээнд авч үзэв.
2. *Дүрэм журмын тогтолцоо.* Их сургуулийн дүрэм журам нь стратегийг хэрэгжүүлэхэд гарч болох эрсдэлүүдээс сэргийлсэн хязгаарлалтуудыг тусгасан байх шаардлагатай. Энэ хүрээнд төрийн өмчийн 6 их сургуулийн албан ёсны вэб сайтад байршуулсан их сургуулийн дүрэм, удирдах ба эрдмийн зөвлөлийн дүрэм болон дотоод хяналтын тогтолцоог тодорхойлсон бусад дүрэм, журмуудыг харьцуулан судлав.
3. *Хяналтын интерактив тогтолцоо.* Нэгдмэл үнэт зүйлс, итгэл үнэмшлээр хөглөгдсөн байгууллагын гишүүдийн оролцоог хангасан интерактив хяналт. Их сургуулиудын дүрэм журамд удирдлагын үйл явцад багш ажилтан нарын оролцоог хангасан заалтууд орсон байдлыг судалж шинжилгээ хийв.
4. *Гүйцэтгэлийг хянах оношилгооны тогтолцоо.* Их сургууль тавьсан зорилгодоо хүрч чадсан эсэхийг сургалт ба судалгааны ажлын чанарыг илэрхийлэх үзүүлэлтүүдээр болон санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгээр тодорхойлж болно. Хяналтын оношилгооны тогтолцоог судлахдаа санхүүгийн үр дүнд төвлөрч Үндэсний аудитын газар [4] ба төрийн өмчийн 6 их сургуулийн шилэн дансны вэбсайтад байршуулсан 2019, 2020 оны аудитын тайлангуудыг ашиглав.

3. Хяналтын тогтолцооны харьцуулсан судалгааны үр дүн

3.1. Хяналтын итгэл үнэмшлийн тогтолцоо бүрэлдсэн байдал

Итгэл үнэмшлийн тогтолцоог байгууллагын онцлог, давуу талыг илтгэсэн алсын хараа, үнэт зүйлсээр илэрхийлэгдэнэ. Төрийн өмчийн 6 их сургуулийн тус бүр салбартаа анхдагч, баялаг түүхтэй, өөрийн онцлог, шинж чанартай ба дэлхийн шилдэг их сургуулиудын нэг болохыг алсын хараа болгосон байна. АШУҮИС, МУБИС ба МУИС нь ёс зүйг илүү дээгүүр онцолж үнэт зүйлсдээ тусгасан байна [5, 6, 7, 8, 9, 10, 11].

Хүснэгт 2. Их сургуулиудын алсын хараа, үнэт зүйлс, уриа ба эрхэм зорилго

Их сургууль	Алсын хараа, үнэт зүйлс, уриа, эрхэм зорилго
АШУҮИС	<p><u>Алсын хараа:</u> Дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болно.</p> <p><u>Үнэт зүйлс:</u></p> <ul style="list-style-type: none"> • Бидний бүтээсэн түүх, оюуны бүтээл, нэр хүнд, эв нэгдэл • Эрдэм мэдлэг, ёс зүйтэй чадварлаг багш судлаач, эмч нар • Эрдэмд шамдагч, эрүүл, чийрэг, эрч хүчтэй оюутан залуус • Бүтээлч манлайлагч манай төгсөгчид <p><u>Уриа:</u> Эрүүл ирээдүйг хамтдаа бүтээ</p> <p><u>Эрхэм зорилго:</u> Шинжлэх ухаан боловсрол, эрүүл мэндийн салбарт манлайлагч их сургууль байхад оршино</p>

МУБИС	<p><u>Алсын хараа:</u> Ази тивийн хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий боловсролын эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн төв болох</p> <p><u>Үнэт зүйлс:</u></p> <ul style="list-style-type: none"> • Сурах арга барилтай, хүнлэг ёс зүйтэй оюутан • Судлан шинжлэх, суралцахуйг хөтлөх эрдэмтэн багш <p><u>Уриа:</u> Бүтээлч багш-хөгжлийн түлхүүр</p> <p><u>Эрхэм зорилго:</u> Нийгмийн болон хувь хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн мэргэшсэн багш, боловсролын бусад салбарын мэргэжилтэн бэлтгэх</p>
МУИС	<p><u>Алсын хараа:</u> Дэлхийн түвшний их сургууль болох. Үүний дүнд 2024 онд МУИС нь чөлөөт мэдлэг буюу "либерал арт" уламжлалд суурилсан, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болж, улмаар Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж орно.</p> <p><u>Үнэт зүйлс:</u></p> <ul style="list-style-type: none"> • Академик эрх чөлөө • Хөгжлийн жишиг • Ес зүй • Манлайлал • Хүндлэл/ Урамшуулал <p><u>Эрхэм зорилго:</u> Шинжлэх ухааны үндсэн салбаруудыг хамарсан чөлөөт мэдлэг буюу "либерал арт" уламжлалд суурилсан хөтөлбөртэй, байгалийн ухаан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь асуудлаар сургалт, судалгааны ажлыг тогтвортой эрхэлж, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх</p>
СУИС	<p><u>Алсын хараа:</u> Бүс нутгийн шилдэг сургуулиудын эгнээнд багтсан соёл, урлагийн төрөлжсөн их сургууль болох</p> <p><u>Үнэт зүйлс:</u></p> <ul style="list-style-type: none"> • Арга билэг • Үндэсний соёл • Авьяас • Хөдөлмөр • Бүтээлч сэтгэлгээ • Эрх чөлөө • Сургалт, урлаг, ёс суртахууны өндөр хэм хэмжээ <p><u>Уриа:</u> Бид сайн сайханд дагуулна</p> <p><u>Эрхэм зорилго:</u> Соёл урлагийн мэргэжлээр авьяаслаг бүтээлч, шилдэг уран бүтээлч, мэргэжилтнийг бэлтгэж, төрөөс соёл урлагийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц судалгааны ажлыг явуулдаг Монгол үндэсний соёл урлагийн гол уурхай болоход чиглэгдэнэ.</p>
ХААИС	<p><u>Алсын хараа:</u> Бүс нутгийн шилдэг их сургуулиудын эгнээнд хүрэх</p> <p><u>Үнэт зүйлс:</u></p> <ul style="list-style-type: none"> • Оюуны чадамж бүхий эвсэг, эрдмийн хамт олон • Шинжлэх ухаан технологи, инновацын дэвшлийн төлөө тэмүүлэл • Нүүдлийн соёл иргэншлийн үнэт өв уламжлал • Төгсөгчдийн бүтээлч хандлага, ур чадвар, дадал дүй <p><u>Уриа:</u> Тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулахын төлөө</p>

	<p><u>Эрхэм зорилго:</u> Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн чиглэлээр шинжлэх ухаан, сургалт, үйлдвэрлэлийг хосолсон бүс нутгийн тэргүүлэх их сургууль байх</p>
ШУТИС	<p><u>Алсын хараа:</u> Дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээнэ</p> <p><u>Үнэт зүйлс:</u></p> <ul style="list-style-type: none"> • Шилдэг гүйцэтгэл • Уламжлал • Тэмүүлэл • Инновац • Сайн-хүмүүнлэг засаглал <p><u>Уриа:</u> Асуудлыг бүтээлчээр шийдье!</p> <p><u>Эрхэм зорилго:</u> Эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох хүн-байгальд ээлтэй шинжлэх ухаан, технологийн мэдлэг, инновацыг бүтээх авьяас чадварын төвлөрөл байна.</p>

Эх үүсвэр: Вэб хуудсанд байршуулсан мэдээллээр (2022 оны 1 сарын байдлаар)

3.2 Хяналтын дүрэм журмын тогтолцоо бүрэлдсэн байдал

МУИС ба АШУҮИС нь 1942 онд байгуулагдсан ууган сургуулиуд болохоо онцолж МУИС нь мөн “үндэсний” болон “бие даасан” болохоо тодотгосон байна. АШУҮИС өөрийн удирдлагатай, харин МУИС, ХААИС ба СУИС нь “хамтын болон өөрийн удирдлагатай” болохоо дурджээ. МУИС ба СУИС нь “нийтийн өмчид суурилсан” гэж тодорхойлсон бол МУБИС “төрийн өмчийн”-х байна. ШУТИС нь өмчийн ба удирдлагын хэлбэрийг томъёололдоо тусгаагүй байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Их сургуулийн дүрэмд сургуулийн томъёолол ба батлагдсан огноо

Их сургууль (Дүрэм батлагдсан огноо)	Дүрэмд сургуулийн статусын томъёолол
АШУҮИС (2020.09.23)	АШУҮИС нь 1942 онд байгуулагдсан ууган сургууль бөгөөд эрдэм шинжилгээ, боловсрол, эрүүл мэнд, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг өөрийн удирдлагатай, ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн.
МУБИС (2017.08.28)	МУБИС нь төрийн өмчийн, ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд мөн.
МУИС (2017.06.14)	МУИС нь 1942 онд байгуулагдсан, нийтийн өмчид суурилсан, хамтын болон өөрийн удирдлагатай, үндэсний хэмжээний бие даасан хуулийн этгээд мөн.
СУИС (2019.04.03)	СУИС нь нийтийн өмчид суурилсан, хамтын болон өөрийн удирдлагатай ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байна.
ХААИС (2019.04.25)	Хамтын болон өөрийн удирдлагатай, нийгэмд үйлчилдэг, төрийн өмчийн их сургууль болно.
ШУТИС (2017.05.16)	ШУТИС нь бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага мөн.

Хүснэгт 4. Их сургуулийн дүрэм журмын тоо

№	Их сургууль	Нийт дүрэм журмын тоо	Санхүүгийн сахилга багтай холбоотой дүрэм журмын тоо
1	АШУҮИС	39	5
2	МУБИС	12	3
3	МУИС	59	2
4	СУИС	73	4
5	ХААИС	28	1
6	ШУТИС	75	3

Эх үүсвэр: Вэб хуудсанд байршуулсан мэдээллээр (2022 оны 1 сарын байдлаар)

Хамгийн олон дүрэмтэй нь ШУТИС, хамгийн цөөн тооны дүрэмтэй нь МУБИС байна (Хүснэгт 4). Их сургуулиуд санхүүгийн сахилга батыг сахих, сургуулийн өмч хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зарцуулах талаар дараах байдлаар дүрэм журамдаа тусгасан байна. Үүнд:

1. АШУҮИС нь “АШУҮИС-ийн дүрэм”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Худалдан авалт, тендер зохион байгуулах хэлтсийн ажиллах журам”, “Ёс зүйн дүрэм”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам” гэсэн 5 дүрэм журамд санхүүгийн сахилга батыг сахих талаар тодорхой оруулжээ.

2. МУБИС нь санхүүгийн сахилга батыг сахих талаар “Ёс зүйн дүрэм”, “Дотоод журам”, “Санхүүгийн журам”-д тусгажээ.
3. МУИС нь “Багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”, “МУИС-ийн дотоод аудитын журам”-тай байна.
4. СУИС-ийн “Багш ажилтны ёс зүйн дүрэм”, “Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны журам”, “Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба горим”, “Эд хөрөнгө хариуцагчийн дүрэм”-д санхүүгийн сахилга батыг дурдсан байна.
5. ХААИС-д санхүүгийн сахилга батыг “Ажиллагсдын ёс зүйн дүрэм”-д тусгасан байна.
6. ШУТИС-ийн “Багш, ажилтны ёс зүйн дүрэм”, “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх журам”, “Дотоод хяналт шалгалтын журам” – санхүүгийн сахилга батыг сахих тухай оруулжээ.

Санхүүгийн сахилга батыг хэрхэн сахих талаар хамгийн тодорхой онцолж анхаарсан нь АШУҮИС бол, хамгийн бага авч үзсэн нь ХААИС байна.

3.3 Хяналтын интерактив тогтолцоо бүрэлдсэн байдал

Байгууллагын гишүүд байгууллагыг хөгжүүлэх эрмэлзэлтэй, гүйцэтгэлийн үйл явц, гарах үр дүнд санаа тавьдаг нөхцөлд хамт олны оролцоонд тулгуурласан интерактив хяналт хэрэгжих боломжтой. Хөгжил нь хамтын хүчин чармайлтын үр дүнд бий болж, гишүүн бүрийн оролцоо ирээдүйн хөгжилд үнэ цэнтэй болоход итгэл үнэмшил бүхий байгууллагын соёл тогтсон, гишүүдийн хөгжилд хувь нэмэр оруулах эрхийг дүрэм журмаар албан ёсоор баталгаажуулсан нөхцөлд “Интерактив хяналтын тогтолцоо” бүрэлдэнэ.

Хяналтын интерактив тогтолцоог хамт олны санал бодол удирдлагыг томилох, гүйцэтгэлийг үнэлэхэд ач холбогдолтой байхаар дүрэм журамд тусгасан байдлаар төрийн өмчийн 6 их сургуулийн удирдлагын бүтцийг харьцуулав. Удирдлагын бүтцийг удирдах зөвлөл, эрдмийн зөвлөл, их сургуулийн захирал (ректор), захиргааны (захирлын) зөвлөлийн хүрээнд авч үзэв. Одоо мөрдөгдөж буй дээд боловсролын тухай хуулиар удирдах зөвлөлийн 51-ээс дээш хувийг үүсгэн байгуулагч буюу төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл байх ба боловсролын асуудал эрхэлсэн сайд томилно. Үлдсэн цөөнх хэсгийг сургуулийн хамт олон, оюутан, төгсөгч, бизнесийн байгууллагын төлөөлөл бүрдүүлнэ. Их сургуулийн мэргэжлийн удирдлагыг Эрдмийн зөвлөл хангах бөгөөд эрдмийн зөвлөлийн гишүүд нь их сургуулийн эрдэмтэн багш нарын төлөөлөл байдаг. Их сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааны гүйцэтгэх удирдлагыг их сургуулийн захирал ба захиргааны зөвлөл гүйцэтгэдэг.

Хүснэгт 5. Их сургуулиудын удирдлагын бүтцийн харьцуулалт

Их сургууль	Дэд захирлууд	Захиргааны нэгжүүд	Захирлын шууд удирдлага доорх нэгжүүд
АШУҮИС	1) Эрдэм шинжилгээ, гадаад харилцаа хариуцсан 2) Боловсрол хариуцсан, 3) Эмнэлэг хариуцсан, 4) Санхүү, эдийн засаг хариуцсан	– 12 газар – 1 алба – 8 бүрэлдэхүүн сургууль – 3 салбар сургууль – 1 лицей сургууль – 4 эмнэлэг, 2 сувилал – 4 хүрээлэн, институт	1) Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, 2) Захиргаа хүний нөөцийн газар 3) Цахим хөгжил маркетингийн газар

		– Оюутны байр, цэцэрлэг, хэвлэх үйлдвэр	
МУБИС	1) Сургалт эрхэлсэн 2) Эрдэм шинжилгээ эрхэлсэн 3) Гадаад харилцаа эрхэлсэн 4) Захиргаа дотоод асуудал эрхэлсэн	– 10 алба – 7 бүрэлдэхүүн сургууль – 1 салбар сургууль – 1 лаборатори ЕБС – 1 лаборатори цэцэрлэг – 3 төв – Номын сан, хэвлэх цех	1) Чанарын баталгаажилт, хяналт үнэлгээний алба 2) Дотоод ажлын алба
МУИС	1) Сургалт, оюутан хариуцсан, 2) Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан, 3) Санхүү, төлөвлөлт хариуцсан	– 4 газар – 1 алба – 5 хэлтэс – 6 бүрэлдэхүүн сургууль – 2 салбар сургууль – 15 хүрээлэн, төвүүд – 1 ахлах сургууль – 2 төв – Номын сан, хэвлэх үйлдвэр, эмнэлэг, хичээл ба оюутны байр, барилгын баг, сантехник, цахилгаан, засварын хэсэг	1) Хяналт-Шинжилгээ үнэлгээний алба
СУИС	1) Боловсролын асуудал 2) Хяналт шинжилгээ, хөрөнгө оруулалт эрхэлсэн	– 7 газар – 1 алба – 7 бүтцийн сургууль, хүрээлэн – 1 коллеж, 1 ахлах сургууль – 2 төв – Номын сан, дотуур байр, цэцэрлэг, зуслан, оюутны театр	1) Уран бүтээлийн зөвлөл 2) Хөтөлбөр чанарын хороо 3) Дотоод аудитор*
ХААИС	1) Чанарын удирдлага, зохицуулалт хариуцсан 2) Эрдэм шинжилгээ хариуцсан 3) Сургалтын бодлого зохицуулалт хариуцсан 4) Эдийн засаг хөгжлийн алба хариуцсан	– 4 алба – 6 бүрэлдэхүүн сургууль – 4 хүрээлэн – 4 төв, музей	Дотоод аудитын талаар дүрэмд тусгагдаагүй
ШУТИС	1) Сургалт, оюутны асуудал эрхэлсэн 2) Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн 3) Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн 4) Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн 5) Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн	– 5 газар – 8 алба – 11 бүрэлдэхүүн сургууль – 2 салбар сургууль – 1 коллеж, 1 ахлах сургууль – 4 төв – 4 хүрээлэн, 2 төв – Музей дадлагын полигон, хэвлэлийн газар	– Захиргаа, хүний нөөцийн газар – Дотоод аудитын алба**

Тайлбар: Төрийн хэмнэлтийн тухай хуулиар 2022 оноос төрийн өмчийн их сургуулиудад дэд захирлын албан тушаалтай байхыг хориглосон.

* дотоод аудиторын үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулна гэсэн боловч журам нь байгаагүй

*** Дотоод аудитын алба ШУТИС-ийн дүрэмд захирлын шууд удирдлагад байхаар тусгагдсан боловч Хяналт шинэжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирлын удирдлага доор ажилладаг.*

Эх үүсвэр: их сургуулиудын вэб дээр байршуулсан мэдээлэл

Төрийн өмчийн их сургуулийн захирал буюу ректорыг томилоход одоогийн мөрдөгдөж буй эрх зүйн орчны хүрээнд хамт олны оролцоо хангагдаагүй гагцхүү Засгийн газрын гишүүн буюу БШУЯ-ны сайд шийдвэрээр томилогдож байна. Удирдах зөвлөлийн багш нарын төлөөлөл болох гишүүдийг МУИС ба СУИС-д “үндсэн орон тооны багш нарын 50-аас доошгүй хувийн ирцтэй хурлаас нууц санал хураалтаар сонгоно”, ШУТИС-д “багш оюутан төгсөгчдийн төлөөллийг хамт олны хурлаас сонгоно” гэж заасан, харин бусад их сургуулиудад хамт олны саналыг авч үзэх талаар дүрэмд тусгаагүй байна (Хүснэгт 6).

Удирдлагын тогтолцоог дүрэмд тусгасан байдлыг харьцуулахад ШУТИС-ийн дүрэмд захирлын зөвлөлд эрх мэдлийг илүүтэй олгосон байдал ажиглагдав. Тухайлбал, бусад сургуулиудын дүрэмд удирдлагын тогтолцоог 1) удирдах зөвлөл, 2) эрдмийн зөвлөл, 3) захирал, 4) захирлын зөвлөл гэсэн дарааллаар авч үзсэн байхад ШУТИС-ийн дүрэмд захирлыг захирлын зөвлөлийн дараа эрэмбэлсэн байна. Түүнчлэн бусад сургуулийн дүрэмд тухайн сургуулийн хөгжлийн бодлого хөтөлбөрийг боловсруулах чиг үүргийг зөвхөн захиралд оногдуулсан байхад ШУТИС-д энэ чиг үүргийг захирлын зөвлөлд давхар оногдуулжээ. МУИС-ийн дүрэмд захиргааны зөвлөлийг “МУИС-ийн захирлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад ... дэмжлэг үзүүлэх үүрэгтэй” гэсэн бол ШУТИС-ийн дүрэмд “ШУТИС-ийн хамтын удирдлагын зарчмыг хэрэгжүүлэн захиргааны удирдлагаар хангах...” зорилготой болохыг тусгажээ. ШУТИС-д захирлын зөвлөл нь захирлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүргээс давсан чиг үүрэгтэй, захирлын эрх мэдлийг захирлын зөвлөлд шилжүүлсэн дүрэм батлагдсан гэж үзэж байна.

Хүснэгт 6. Их сургуулиудын интерактив тогтолцоо буюу удирдлагыг томилоход хамт олны саналыг хурааж оролцуулах эрхийг дүрэмд тусгасан байдлын харьцуулалт

Их сургууль	Захирлыг томилоход*	Удирдах зөвлөлийн гишүүдийг	Эрдмийн зөвлөлийн гишүүдийг	Бүрэлдэхүүн сургуулийн захирлыг томилоход
АШУУИС	-	-	-	-
МУБИС	-	-	-	-
МУИС	-	+	+	+
СУИС	-	+	-	
ХААИС	-	-	-	
ШУТИС	-	+	-	

*Тайлбар: * 2022 оны 10 сарын 25-нд “Төрийн өмчийн зарим их дээд сургуулийн төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах нийтлэг журам” батлагдсан боловч сонгон шалгаруулалтад хамт олны саналыг хураахгүйгээр удирдах зөвлөлийн шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсгийн үнэлгээгээр Засгийн газрын гишүүн шийдвэрлэхээр заасан байна.*

Интерактив тогтолцоо нь удирдлагыг сонгоход хамт олны санал нөлөөтэй байх нөхцөлд хэрэгжинэ. Тодруулбал, “хамт олны саналыг харгалзан захирал” томилно гэсэн томъёололтой дүрэмд тусгагдсан бол интерактив тогтолцоо бүрэлдсэн гэж үзэх боломжгүй. Гагцхүү “хамт олны нууц санал хураалтаар тодорхойлно” гэж тодорхой заасан дүрэмтэй тохиолдолд интерактив тогтолцоо биеллээ олж чадна. Тухайлбал, МУИС-т бүрэлдэхүүн сургуулийн захирлыг томилоход үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессор нарын 50-иас дээш хувийн ирцтэй хурлаар нууц санал хураалт явуулж, хамгийн олон санал

авсан 2 нэр дэвшигчээс МУИС-ийн захирал сонгон 3 жилийн хугацаагаар томилно гэж заасан байна.

Төрийн өмчийн 6 их сургуулиас ганцхан МУИС-т тэнхимийн эрхлэгчээс их сургуулийн захирал, эрдмийн зөвлөл ба удирдах зөвлөлийн гишүүдийг багш нарын нууц санал хураалтаар сонгох эрхийг дүрэмд тодорхой тусгаж баталгаажуулсан байна. Удирдах зөвлөл нь захирлыг томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавих чиг үүрэгтэй, эрдмийн зөвлөл нь захирлын үйл ажиллагааны талаар саналаа удирдах зөвлөлд оруулах чиг үүрэгтэй байна. Удирдах зөвлөл дэх багшийн төлөөллийг үндсэн орон тооны багш нарын 50-аас доошгүй хувийн ирцтэй хурлаас нууц санал хураалтаар сонгоно. Эрдмийн зөвлөлийн гишүүнийг үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессорын гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлаас нууц санал хураалтаар сонгоно. Бүрэлдэхүүн салбар сургуулийн эрдмийн зөвлөл нь бүрэлдэхүүн сургуулийн захирлын үйл ажиллагааны талаар саналаа МУИС-ийн захиралд гаргах эрхтэй. Бүрэлдэхүүн сургуулийн захирлыг судлан шалгаруулах ажлын хэсгийг МУИС-ийн захирлын тушаалаар байгуулна. Ажлын хэсэг шаардлага хангасан нэр дэвшигчдийг тодруулж, үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессор нарын 50-иас дээш хувийн ирцтэй хурлаар нууц санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчээс МУИС-ийн захирал сонгон 3 жилийн хугацаагаар томилно. Бүрэлдэхүүн сургуулийн захирлын ажлыг үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессор нарын хурлаар хэлэлцүүлж нууц санал хураалтаар үнэлнэ. Олонх нь хангалттай гэж үзвэл 1 удаа үргэлжлүүлэн ажиллуулах үндэслэл болно.

СУИС-д МУИС-ийн нэгэн адил Удирдах зөвлөл дэх багш, суралцагчийн төлөөллийг хамт олны 50-иас доошгүй хувийн ирцтэй хурлаас сонгоно. Удирдах зөвлөл нь сургуулийн захирлыг томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавьж болно. Эрдмийн зөвлөлийн гишүүнийг сургуулиас ирүүлсэн саналыг үндэслэн сонгоно. Эрдмийн зөвлөл нь захирлын тайланг жил бүр хэлэлцэж санал дүгнэлтээ төрийн захиргааны төв байгууллага, удирдах зөвлөлд хүргүүлэх чиг үүрэгтэй.

ХААИС-д Эрдмийн зөвлөлийн гишүүдийг их сургуулийн захирлын тушаалаар томилж чөлөөлнө. Бүрэлдэхүүн сургуулийн захирлыг томилох, чөлөөлөх, гэрээг сунгах эсэхийг хамт олны саналыг үндэслэн Удирдах зөвлөлтэй зөвшилцөн шийдвэрлэнэ. Удирдах зөвлөл дэх багшийн төлөөллийг хэрхэн сонгох ба дотоод аудитын талаар дүрэмд тусгагдаагүй. Гүйцэтгэлийг үнэлж хянах үйл явцад багш нарын оролцоог хангасан интерактив тогтолцоог дүрэмд тусгаж баталгаажуулаагүй байна.

ШУТИС-ийн Захирал нь ШУТИС-ийн хамт олон, Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөл, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах үүрэгтэй. Бүрэлдэхүүн болон харьяа сургуулийн захирлыг ШУТИС-ийн захирал томилно. Ингэхдээ хамт олны саналыг харгалзан үзэж болно.

АШУҮИС, МУБИС ба ХААИС нь тус бүр 4, МУИС нь 3, СУИС нь 2 дэд захиралтай байхад ШУТИС нь хамгийн олон нийт 5 дэд захиралтай байна. Үүнд: Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал, Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал, Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал байна. Захиргаа, хүний нөөцийн газар (ЗХНГ) болон Дотоод аудитын алба (ДАА) нь ШУТИС-ийн дүрэмд захирлын шууд удирдлагад

байхаар тусгагдсан боловч ДАА нь удирдлагын бүтцийн албан ёсны зураглалд Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захиралд харьяалагдаж байна.

Хүснэгт 7. Их сургуулиудын интерактив тогтолцоо буюу их сургуулийн захирлыг томилж үнэлэхэд хамт олны саналыг тусгасан байдлын харьцуулалт

Их сургууль	Захирлыг томилох, ажлыг нь үнэлэхэд хамт олны санал
АШУҮИС	Удирдах зөвлөл нь их сургуулийн захирлын тайланг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөх эрхтэй. Эрдмийн зөвлөлд ийм эрх дүрмээр олгогдоогүй.
МУБИС	Удирдах зөвлөл нь сургуулийн захирлын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх үнэлэлт, дүгнэлт өгөх чиг үүрэгтэй. Эрдмийн зөвлөлд ийм эрх дүрмээр тусгагдаагүй.
МУИС	Удирдах зөвлөл нь захирлыг томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавих чиг үүрэгтэй. Эрдмийн зөвлөл нь захирлын үйл ажиллагааны талаар саналаа удирдах зөвлөлд оруулах чиг үүрэгтэй.
СУИС	Удирдах зөвлөл нь сургуулийн захирлыг томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавьж болно. Эрдмийн зөвлөл нь захирлын тайланг жил бүр хэлэлцэж санал дүгнэлтээ төрийн захиргааны төв байгууллага, удирдах зөвлөлд хүргүүлэх чиг үүрэгтэй.
ХААИС	Захирал нь үйл ажиллагааны үр дүнгийн талаар хамт олон, удирдах зөвлөлд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тайлагнана.
ШУТИС	Захирал нь ШУТИС-ийн хамт олон, Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөл, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах үүрэгтэй.

АШУҮИС, МУБИС, МУИС ба СУИС-ийн Удирдах зөвлөл нь сургуулийн захирлыг томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавих эрхтэй бол ШУТИС ба ХААИС Удирдах зөвлөлд ийм эрх олгогдоогүй байна (Хүснэгт 7).

4.4 Хяналтын оношилгооны тогтолцоо бүрэлдсэн байдал

Хяналтын оношилгооны тогтолцоо нь санхүүгийн үр дүнд тулгуурлан гүйцэтгэлийг хянаж чадаж байгаа эсэхээр илэрнэ. Хяналтын оношилгооны тогтолцоо бүрэлдэж чадсан нөхцөлд санхүүгийн үр дүнгийн үзүүлэлтүүд эерэг гарч байгууллагын ашиг, хөрөнгө өсөн нэмэгдэнэ. Хяналтын тогтолцоо доголдож байгаа бол санхүүгийн үзүүлэлтүүд сайн байх аргагүй юм. 2018, 2019, 2020 ба 2021 онуудын санхүүгийн үр дүнг харьцуулахад 4 жил дараалан ашигтай гарсан нь интерактив тогтолцоо харьцангуй бүрэлдэж чадсан МУИС байна. 2018 онд хамгийн муу үр дүнтэй байсан АШУҮИС нь 2021 онд хамгийн сайн үр дүнтэй болж эрс сайжирсан байна. АШУҮИС-д хяналт нь интерактив тогтолцооноос илүү зохицуулалтын механизмаар хэрэгждэг, тухайлбал санхүүгийн сахилга батыг бусад сургуулиас илүүтэй дүрэм журам тусгасныг онцлох нь зүйтэй.

Хүснэгт 8. Их сургуулиудын санхүүгийн нийт үр дүн, тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) 2018-2021 (мян. төг)

Их сургууль	2018	2019	2020	2021
АШУҮИС	-93,422,193.986	4,440,700.00	3,935,029.346	23,209,448.589
МУБИС	3,870,518.823	1,930,754.56	-209,201.134	-2,412,721.101
МУИС	6,968,898.369	8,693,721.90	3,430,514.642	2,573,609.860
СУИС	-356,655.707	-1,217,538.10	499,833.173	-719,039.669
ХААИС	370,453.492	-7,179,963.10	1,217,336.431	-1,150,016.751
ШУТИС	4,862.721	-1,200,810.40	-2,258,608.647	12,984,707.720

АШУҮИС ба МУБИС-д Капитал банк дампуурсантай холбоотой авлага үүссэн, МУИС-ийн газар нь өөр эзэмшигчид шилжсэн, ШУТИС-ийн төсөл, гэрээт ажлын хяналт ба худалдан авах ажиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг шалгах зэрэг асуудлууд илэрсэн байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Аудитын тайланд дурдагдсан анхаарах асуудал, 2019 ба 2021 он

Их сургууль	Анхаарах асуудал, 2019 он	Анхаарах асуудал, 2021 он
АШУҮИС	<p>1. Капитал банк дампуурсантай холбоотойгоор тус банканд байршуулж байсан 4,087.3 сая төгрөгийн хадгаламжийн мөнгийг авах нэхэмжлэл үүсгэсэн.</p> <p>2. ТӨБЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн албан даалгавраар шинэ цогцолборын А, Б блокийн барилга угсралтын ажил гүйцэтгэсэн 6 компанийг гэрээний үүргээ зөрчсөн гэж 10 хувийн алданги тооцсоноос 2 компаниас нийт 117.9 сая төгрөгийн авлагатай. Эдгээр компани уг тооцоог хүлээн зөвшөөрөхгүй шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.</p>	<p>1. Сургууль сургалтын төлбөрийн программтай, сургалтын төлбөрийн тооцоог оюутан нэг бүрээр хийдэг боловч энэхүү программ нь иж бүрэн биш, санхүүгийн программтай холбогдоогүй байна. Дараа жилийн аудитаар сургалтын төлбөрийн программ хангамжийг санхүүгийн программд холбогдсон эсэх, сургалтын төлбөрийн орлого болон авлагын бүртгэлд анхаарах</p> <p>2. Сургуулийн харьяа эмнэлгүүд нь 2022 оноос үйл ажиллагааны программ хангамжтай болж байгаа бөгөөд эмнэлгийн орлого, зарлагын тооцоо нь хянагдаж байгаа эсэхэд анхаарах</p>
МУБИС	<p>Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримтын бүрдэл, өндөр дүнтэй бараа ажил үйлчилгээний худалдан авалтын тендер шалгаруулалт холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж байгаа эсэх, хандив тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.</p>	<p>1. Капитал банкнаас авах 2,063.11 сая төгрөгийн авлагыг Капитал банк, МУБИС, "Ви эйч энд би" ХХК-ийн гурвалсан гэрээгээр "Ви эйч энд би" ХХК руу шилжүүлэн, тус компани авлагыг дуусаагүй барилгаар барагдуулахаар тохиролцсон. Дуусаагүй барилгыг Улсын комиссын дүгнэлт гаргуулан 2021 онд сургуульд хүлээлгэн өгөхөөр гэрээнд тусгасан боловч цар тахлын улмаас тайлант онд багтаан барилгыг хүлээлгэн өгөөгүй бөгөөд удирдлагын зүгээс дараагийн тайлант жилд хүлээн авахаар тодорхой шатны арга хэмжээ авч, хуваарь гаргуулан ажиллаж байна.</p> <p>2. Сургууль Чингис хаан банкны өөрийн дансанд байгаа 247.0 сая төгрөгийг Хаан банкны данс руугаа шилжүүлэн авах хүсэлтийг банкинд гаргасан боловч банкны санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан мөнгийг цувуулан өгөх талаар сургуульд мэдэгдсэн бөгөөд 2022 оны 03 дугаар сарын 11-ний байдлаар 46.0 сая төгрөгийг</p>

		сургуулийн Хаан банкны данс руу шилжүүлээд байна
МУИС	<ol style="list-style-type: none"> 1. Дуусаагүй барилга нэрээр бүртгэж тайлагнасан 391 метр квадрат газрыг өөр эзэмшигч нэр дээрээ шилжүүлэн авч 4 давхар барилгын карказд хөрөнгө оруулсан байна. 2. Боловсролын байгууллагын зориулалтаар эзэмших зориулалттай 12,806.0 м.кв газарт өөр байгууллагын санхүүжүүлэлтээр Спорт цогцолборын барилгын 3 давхар карказ баригдсан байна. 	<ol style="list-style-type: none"> 1. БШУЯ-аас хэрэгжүүлж буй "Инженер технологийн дээд боловсрол" төслөөс нийлүүлэх 94 нэр бүхий төрлийн багаж төхөөрөмж ирүүлсэн ба хөрөнгийг бүрэн хүлээн авсан үед орлогоор бүртгэх тул дараагийн аудитаар авч үзэх. 2. Завхан, Эрдэнэт дэх салбар сургуулийн сургалтын хичээл сонголтын программын мэдээлэл ирүүлээгүй тул тус салбар сургуулиудын авлага, урьдчилж орсон орлогын тулгалтыг хийгээгүй болно
СУИС	-	-
ХААИС	-	Салбар сургуулиудын үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт, тайлагналт, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг дараагийн аудитаар анхаарах
ШУТИС	<p>24 сар ба түүнээс дээш насжилттай, сургуулиа төгссөн, сургуулиас гарсан, шилжсэн эсвэл сураггүй гэсэн төлөвтэй оюутанд хамаарах 8.6 сая төгрөгийн сургалтын төлбөрийн орлогыг урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэн хэвээр байна.</p> <ul style="list-style-type: none"> • Хэвлэх үйлдвэрээс бүрэлдэхүүн сургуулиудад үзүүлсэн үйлчилгээ (Ном хэвлүүлсэн)-ний 355.6 сая төгрөгийн орлого болон бүрэлдэхүүн сургууль тус бүрийн зардал нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахдаа тохируулга хийж, орлого, зардлын устгах бичилтийг хийгээгүй. 	Төсөл гэрээт ажилтай холбоотой асуудалд БШУЯ-ны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, гэрээт ажлын гүйцэтгэлийг тусгайлан авч үзэх, мөн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байгаа эсэхийг шалгах

Тайлбар: Төрийн өмчийн их сургуулиудын аудитын дүгнэлтэд “2019 онд Боловсролын тухай хуульд өөрчлөлт орж төрийн өмчийн их дээд сургуульд улсын төсвөөс санхүүжилт олгохгүй болсонтой холбогдуулан тэдгээр сургуулийн улсын “төсөвт” гэсэн статус болон үүнтэй холбогдуулан Нягтлан бодох бүртгэлийн ямар стандартыг мөрдөх болохыг эргэж харж, бодлогын баримт бичигт тодорхойлох нь зүйтэй” болохыг анхааруулав. Дээрх 6 их сургууль нь улсын төсвөөс санхүүжилт авдаггүй боловч улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн улсын бүртгэлийн гэрчилгээтэй /статустай/ байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.


2019 оны байдлаар МУИС нь бакалавр, магистр, докторын оюутны тоогоор хамгийн олон бол ШУТИС нь багшийн тоогоор хамгийн олон байна. Харин МУБИС нь хамгийн олон гадаад оюутантай их сургууль байна. Их сургууль тус бүр өөрийн онцлогтой мэргэжлийн чиглэлээс хамааран цар хүрээ, оюутны тоо болон ажиллагчдын хэмжээ ялгаатай тул шууд механикаар санхүүгийн үзүүлэлтүүдийг харьцуулах нь өрөөсгөл. Иймээс аудитын тайланд тусгагдсан санхүүгийн үзүүлэлтүүдийг БШУЯ-ны 2018-2019 оны хичээлийн жилийн статистикт тусгагдсан оюутан ба ажиллагчдын тоонд харьцуулж тооцоолов. Санхүүгийн үр дүн хамгийн өндөртэй МУИС нь нэг оюутнаас олох орлого нь нэг оюутанд зарцуулагдах зардлаасаа буй давж буй цорын ганц их сургууль болох нь тогтоогдов. Бусад 5 их сургуулийн нэг ажиллагчид оногдох орлого нь нэг ажиллагчид оногдох зардлаасаа бага байна. Дадлагын зардал АШУҮИС-ийн оюутанд хамгийн өндөр, ХААИС-ийн оюутанд хамгийн бага зарцуулагджээ (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Их сургуулиудын оюутны ба ажиллагчдын тооны үзүүлэлтүүд, 2019 он

Үзүүлэлт	АШУҮИС	МУБИС	МУИС	СУИС	ХААИС	ШУТИС
Нийт оюутан	7,921	12,953	19,864	3,206	10,460	17,924
-Бакалавр оюутны тоо	7,913	11,148	16,856	2,924	7,053	15,983
-Магистр оюутны тоо	1,151	2,011	3151	226	2,756	1672
-Доктор оюутны тоо	292	704	911	56	651	269
Гадаад оюутны тоо	124	662	423	259	110	27
Ажиллагчдын тоо	891	945	1314	592	817	1772
-Үндсэн багш	547	433	692	325	464	963
Нэг багшид ноогдох оюутны тоо	14.5	29.9	28.7	9.9	22.5	18.6
Нэг оюутнаас олох орлого	4130.5	2471.1	2814.7	2723.7	1250.3	3058.5
Нэг оюутанд оногдох зардал	4459.5	2549.8	2533.1	3470.5	2166.6	3284.5
Нэг оюутанд оногдох дадлагын зардал	582.7	167.8	474.7	157.6	73.7	355.2



Өгөгдлийн эх үүсвэр: БШУЯ-ны статистик ба их сургуулиудын 2019 оны аудитын тайлангууд


МУИС ганцаараа 2020 оныг эс тооцвол нэг ажиллагчид ноогдох орлого нь зарлагаа давсан байна. Дээрээс доошоо удирдлагын шийдвэр гаргалттай бюрократ тогтолцоотой боловч санхүүгийн сахилга батыг дүрэм журамдаа бусдаас илүү тусгаж чадсан АШУҮИС нь 2021 онд орлого нь харьцангуй өндөр байна. 2020 онд бүх 6 их сургуульд цар тахлын нөхцөл байдал хүнд туссан ч санхүүгийн сахилга бат, ёс зүйтэй байдлыг маш сайн дүрэмжүүлсэн нь АШУҮИС-д давуу байдал бий болгож орлого өсөхөд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж байна. Адилхан 2019 оны 4 сард дүрмээ шинэчилсэн ХААИС ба СУИС-ийг харьцуулбал удирдлагын үйл ажиллагаанд багш ажилтны оролцоог тусгаж чадсан байдлаараа МУИС-ийн дүрэмд хамгийн их дөхөж очсон СУИС нь орлого ба зарлагын ялгааг ХААИС -аас илүү бууруулж чадсан байна.



Зураг 1. Нэг ажиллагчид ноогдох орлого ба зарлагын ялгаа, 2019-2021


ШУТИС-ийн багш нарт хамгийн бага бичиг хэрэг, хангамж, томилолт, зочны зардал, гэхдээ хамгийн их бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамж оногдсон байна. Цар тахлын үед бүх 6 их сургууль томилолт зочны зардлаа эрс танасан байдал ажиглагдав. МУИС ба АШУҮИС нь харьцангуй өндөр цалинтай, СУИС ба ШУТИС нь харьцангуй бага цалинтай байна. Дээрх зардлуудын хувьд сургууль бүр адилгүй, зардлын дүн ялгаатай байхад үндсэн хөрөнгийн элэгдэл харьцангуй жигд дүнтэй байна.





Зураг 2. Нэг ажиллагчид ноогдох зарим зардлуудын харьцуулалт, 2018-2021 (мян.төг)

Оюутнуудад чиглэсэн зардлыг хэмжээг тодорхойлох хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын нийт үйл ажиллагааны зардалд эзэлж буй хувиар харьцуулахад МУИС-ийнх бусдаасаа илт өндөр хувийг эзэлж байна. 2021 оны хувьд ХААИС-ийн дадлагын зардлын эзлэх хувь хамгийн бага байна.



Зураг 3. Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын үйл ажиллагааны нийт зардалд эзлэх хувь

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгаа нь дүрэм журмын болон санхүүгийн үзүүлэлтүүдэд түлхүү тулгуурлан төрийн өмчийн 6 их сургуулиудын хяналтын тогтолцоонд дүн шинжилгээ хийсэн болно. Судалгаа нь цаг хугацааны хувьд зөвхөн 2018-2021 оныг хамарсан нь өгөгдлийн боломжит олдцоор хязгаарлагдаж, тухайн жилүүдэд болж өнгөрсөн онцгой үйл явдал, тухайлбал цар тахлын нөлөөлөл орсон байхыг үгүйсгэхгүй. Цаашид судалгааны цаг хугацааны цар хүрээг нэмэгдүүлэх нь үр дүнг шалгаж баталгаажуулахад шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт

Менежментийн хяналтын тогтолцоо нь үнэт зүйлс дээр суурилах итгэл үнэмшлийн тогтолцоо, зайлсхийх ёстой эрсдэлүүдийг тусгасан дүрэм журмын тогтолцоо, санхүүгийн гүйцэтгэлийн үзүүлэлтээр хэмжигдэх хяналтын оношилгооны тогтолцоо, байгууллагын гишүүдийн оролцоонд тулгуурласан хяналтын интерактив тогтолцоо гэсэн хоорондоо уялдаа холбоотой 4 дөрвөн тулгуур багана дээр тогтоно. Төрийн өмчийн 6 их сургуулийн хяналтын тогтолцоог дээрх 4 тулгуураар судалж харьцуулаад дараах дүгнэлтүүдэд хүрэв. Хяналтын итгэл үнэмшлийн тогтолцоо 6 их сургуулийн бүгдэд нь тодорхой хэмжээгээр бүрэлдэж тогтсон гэж үзэв. Сургууль тус бүр мэргэжлийн чиглэлийн онцлогийг дагасан шинж чанар давуу талтай ч олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдөх алсын хараатайгаараа ижил байна. Хяналтын дүрэм журмын тогтолцооны хувьд сургуулиудад ялгаатай дүр зураг ажиглагдав.

- ХААИС нь дүрэм журмын хувьд ч хяналтын тогтолцоог хангалттай бүрдүүлээгүй, багшлах хамт олны оролцоог ч хангаж чадаагүй байна. Санхүүгийн үр дүн болох орлого зарлагын ялгаа сөрөг утгатай харьцангуй доогуур байна.
- ШУТИС нь хамгийн олон дүрэм журамтай ч багшлах хамт олны оролцоог хангах хяналтын интерактив тогтолцоог бүрдүүлж чадаагүй, удирдлагын тогтолцоонд эрх мэдэл сарнисан, захиргааны бүтэц нүсэр болсон байна. Үр дүнд нь санхүүгийн үзүүлэлтүүд доогуур, тухайлбал багш нарын цалин ба хангамж харьцангуй бага ч бусад зардал өндөр байна. ШУТИС нь 2020 онд “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг баталсан бөгөөд одоогийн дүрмээ стратеги төлөвлөгөөтэйгөө уялдуулан шинэчлэх шаардлага тулгарч байгаа нь ажиглагдав.
- СУИС нь дүрэм журмын боловсруулалт их байгаа ч интерактив хяналтыг мөн тусгаж чадаагүй байна. Тухайлбал эрдмийн зөвлөл нь удирдах зөвлөлд захирлын талаар үнэлгээ дүгнэлт өгөх чиг үүрэгтэй ч эрдмийн зөвлөлийн гишүүдийг дээрээс нь томилдог болохоор интерактив тогтолцоо бүрэлдэж чадаагүй. Удирдах зөвлөл дэх багш нарын төлөөллийг сонгодог ч удирдах зөвлөлд төрийн төлөөлөл олонх байхаар хуульчлагдсан нөхцөлд хамт олны хяналтыг бүрдүүлэх нөхцөлгүй юм.
- МУБИС интерактив хяналтын тогтолцоогүй боловч дүрэм журмын тогтолцоонд санхүүгийн сахилга батыг тодорхой хэмжээнд бүрдүүлсэн, ёс зүйг эрхэмлэсэн итгэл үнэмшлийг үнэт зүйлсдээ тусгасан байгаагаас санхүүгийн үзүүлэлтүүд харьцангуй дундаж байна.
- АШУҮИС нь ес зүйг үнэт зүйлсдээ эрхэмлэж болон дүрэм журамдаа санхүүгийн сахилга батыг маш тодорхой онцгойлон авч үзсэн нь интерактив хяналтын тогтолцоо бүрдүүлээгүй ч санхүүгийн үзүүлэлтүүдээ сайжруулах нөхцөлийг бүрдүүлжээ.
- МУИС нь академик эрх чөлөөг нэн тэргүүнд тавьж интерактив хяналтын тогтолцоог хамгийн сайн бүрдүүлж чадав. Ингэхдээ бусад сургууль шиг “хамт олны саналд үндэслэн”, “хурлаар сонгоно” гэхгүйгээр шууд тодорхой “үндсэн багш, зөвлөх профессор, зөвлөх дэд профессорын хурлаар нууц санал хураалтаар” эрдмийн болон удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоно. Түүнчлэн дотоод аудитыг шууд захирлын удирдлага доор байрлуулсан бүтэц нь хяналт шинжилгээ эрхэлсэн бүтцийн доор байрлуулах (ШУТИС-ийн тогтолцоо)-аас илүү хараат бус байдлыг хангасан хувилбар юм. Ийнхүү интерактив

тогтолцоог, дүрэм журмын тогтолцоотой уялдуулан бүрдүүлснээр санхүүгийн үр дүн нь хамгийн өндөр байгаа их сургууль юм.

Эрдэм шинжилгээ, инновацыг бий болгох бүтээлч оюуны хөдөлмөр эрхлэх их сургуулийн багш нарт удирдлагын бүтэц бюрократ бус харин бүтээлч академик эрх чөлөөг хангасан байх нь сэтгэл ханамжтай байх үндэс юм. Их сургуулийн хөгжилд юу ч хийж санаачлаад нэмэргүй, удирдлага нь сонсохгүй, хөгжил ирэхгүй гэсэн нөхцөл байдалд ажиллаж байгаа цагт шилдэг гүйцэтгэлийг бус минимум стандартаар ажлаа гүйцэтгээд цалингаа авахаас өөр сонголтгүй болно. Иймээс бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас илүүтэй их сургуулийн хувьд хяналтын интерактив тогтолцоог хангах нь чухал юм. Төрийн өмчийн их сургуульд дээрээс нь албан тушаалд томилдог, дүрэм журамд тогтоосон үзүүлэлтүүдээр хянадаг бюрократ тогтолцоо дангаараа хангалтгүй гэж үзэж байна. Бюрократ хяналтын тогтолцоог багш нарт удирдлагаа сонгох, үнэлэх, дээд байгууллагад саналаа хүргэх боломжийг бүрдүүлсэн интерактив хяналтын тогтолцоотой хослуулах нь илүү оновчтой шийдэл юм. Интерактив хяналтын тогтолцоог бүрдүүлж чадсан МУИС, удирдлагын ёс зүй ба санхүүгийн сахилга батыг нарийн чанд дүрэмжүүлсэн АШУҮИС нь бусад их сургуулиудтай харьцуулахад санхүүгийн хувьд илүү чадамжтай байгааг судалгааны үр дүн харуулав.

Ном зүй

Fielden, J. (2008). Global Trends In University Governance. Washington D.C: The World Bank.

Mintzberg, H. (1979). The Structuring of Organizations. Englewood Cliffs, N.J: Prentice-Hall.

Simons, R. (1994). Levers of Control: How Managers Use Innovative Control Systems to Drive Strategic Renewal . Boston, Massachusetts: Harvard Business School Press.

Төрийн өмчийн их сургуулиудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит <https://audit.mn/?p=3475>

МУИС-ийн алсын хараа, эрхэм зорилго ба үнэт зүйлс <https://www.num.edu.mn/Home/Content/383>

ХААИС-ийн алсын хараа, үнэт зүйлс ба эрхэм зорилго

https://muls.edu.mn/view.php?page_value_sub=ZW5jb2RldXNlcmlkNw==

Их сургуулийн удирдлага, бие даасан байдлын тухай <https://ikon.mn/n/22mf>

ШУТИС 2030 стратеги төлөвлөгөө https://www.must.edu.mn/mn/2030_tovch/

АШУҮИС-ийн дүрэм, бүтэц, алсын хараа, үнэт зүйлс http://www.mnums.edu.mn/?page_id=6750

МУБИС—ийн дүрэм <https://web.msue.edu.mn/Category/Read/6a7c0637-08b8-43fd-a487-93d551052cd4>

СУИС-ийн дүрэм журам <https://mnuac.edu.mn/main/485828>

САЙН БАГШИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ: БАЙГАЛЬ-ЭХ ЛИЦЕЙ АХЛАХ СУРГУУЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР

Б.Булгамаа^{1,2}, Ц.Амартайван^{3*}, Б.Хишигням²

¹ МУИС-ийн харьяа Байгаль-Эх лицей ахлах сургууль

² МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Боловсрол сэтгэл судлалын тэнхим

³ МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Физикийн тэнхим

bulgamaa@num.edu.mn, khishignyam@num.edu.mn, amartaivan@num.edu.mn

Хураангуй

Энэ судалгааны ажлаар Байгаль-Эх лицей ахлах сургуулийн суралцагчдын хувьд “Сайн багш”-ийн тухай ямар ойлголттой байдаг, багшид байх чадваруудын тухай суралцагчдын үзэл бодолд нас, хүйс, судлагдахууны бүлгийн хувьд хамаарал байгаа эсэхийг тогтоохыг зорьсон. Суралцагчдын хувьд тэдний хүсэн хүлээсэн сайн багш ямар чадваруудыг илүү эзэмисэн байхыг, багшаас суралцагчид юуг хүсэн хүлээдэг, лицей сургуулийн багш нарын ямар чадварыг илүү хөгжүүлэх хэрэгцээ байгааг хэрэглэгчийн талаас тодорхойлох судалгаа авав. Судалгаанд МУИС-ийн Байгаль-Эх лицей ахлах сургуулийн 10-12-р ангийн 319 суралцагч, 21 багш хамрагдсан. Сайн багшийг тодорхойлох 4 айн 10 үзүүлэлтийн дагуу асуулга судалгааг авч тоон боловсруулалтыг үл хамаарах t шалгуур, нэг хүчин зүйлийн Anova шинжилгээг хийсэн. “Багш, суралцагчийг сайн сонсдог байх” үзүүлэлтийн хувьд эрэгтэй эмэгтэй суралцагчид ялгаатай бодолтой байна. “Багш суралцагчийн оюун ухааны хөгжилд дэмжлэг үзүүлдэг байх” үзүүлэлтийн хувьд суралцагчдын үзэл бодол наснаас хамааран ялгаатай байв. Санал асуулгаар багш нарын хувьд суралцагчдыг шударга үнэлэх нь хамгийн чухал гэж үзэж байхад суралцагчид багш нар тэдний оюун ухааны хөгжилд дэмжлэг үзүүлдэг байх нь чухал гэж үзсэн.

Түлхүүр үг: сайн багш, багшийн хөгжил, чадамж, t шалгуур, хүчин зүйлийн шинжилгээ

Abstract

A survey from a consumer perspective was conducted on what skills should a good teacher possess, what students expect from a teacher, and what skills of lyceum teachers need to be developed. 319 students of grades 10-12 and 21 teachers of Baigali-Ekh lyceum high school of National University of Mongolia participated in the survey. A questionnaire survey was taken according to 10 features in the framework of 4 competence and for determining a good teacher, and quantitative processing was performed using independent t test and one-factor Anova analysis. Male and female students have different opinions regarding the feature of "Availability/good listener". On the feature of "Facilitator of students intellectual development", the opinions of the students differed depending on their age. While the questionnaire considered it is most important for teachers to evaluate students fairly, students felt it was important that teachers support their learning activities.

Keywords: ideal teacher, teacher development, competence, t test, factor analysis

Удиртгал

Олон улсын чиг хандлага боловсролын чанар, хүртээмжийг бодитой ахиулж, боловсролын үр өгөөжийг нэмэгдүүлэхийг зорьж байгаа өнөө үед Монгол улс ч өөрийн орны боловсролын тогтолцоо, нөхцөл байдалд уялдуулан боловсролын салбарыг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулан урт, богино дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлж байна. Үүний нэг нь монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ын зорилт 2-ын хүрээнд хүний хөгжлийн хэрэгцээг хангахуйц боловсролын салбарын чухал өөрчлөлт болох “Чадварлаг багш” арга хэмжээ юм. Боловсролын үр өгөөжийг өндөр байлгахад сургалтын чанарын асуудал яригдах ба энэ нь ерөнхий боловсролын түвшинд үндсэндээ суралцагчийн сурлагын амжилт юм. Боловсролын салбарын судалгаанаас харахад суралцагчийн сурлагын амжилтад багшийн боловсролын түвшин, мэргэжлийн зэрэг нөлөөлдөг болохыг тогтоосон байдаг (БСШУЯ, 2020). Иймээс багшийн хөгжлийн үр дүнтэй байх загварыг судалж шинжлэн багшийг хэрхэн богино хугацаанд үр дүнтэй, тасралтгүй чадавхжуулах талаар улсын хэмжээнд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ) үндсэн сургалтыг зохион байгуулж, Боловсролын үнэлгээний төв (БҮТ) улс орон даяар багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлж байна.

Багшийн хөгжлийн тухай хууль (УИХ, 2018), Боловсролын тухай хууль (УИХ, 2002), багшийн албан тушаалын тодорхойлолт зэрэгт багш нь мэргэжлээрээ тасралтгүй хөгжих үүрэгтэй гэж заасан. Хэдийгээр багшийг ажлын байрнаас нь хөндийрүүлэн хөгжих боломжийг бүрдүүлэх нь үр дүнтэй боловч багшийн хомсдол ихсэж буй өнөө үед сургуулийн үйл ажиллагаа доголдох сөрөг талтай, мөн эдийн засгийн хувьд зардал ихтэй гэдгийг олон улсын түвшинд судлан тогтоосон байна (OECD, 2010). Манай улсын хувьд багшийн мэргэжлийн хөгжлийг БМДИ голлон хариуцаж ажилладаг. 1,5,10 жилдээ ажиллаж байгаа багшийн үндсэн, 2-4 жилийн багш нарын гэх мэт сургалтуудаар багш нарын хөгжлийг дэмжих боловч 10-аас дээш жил ажиллаж байгаа багш нарт мэргэжлээрээ хөгжих тогтолцоо алга байна. Мөн БМДИ-ийн үндсэн сургалтад 2013 оноос 2019 оны хооронд нийт багш нарын 13.7% хамрагджээ. (БСШУЯ, 2019). Өөрөөр хэлбэл багш нарын 80-аас их хувь нь сургалтад хамрагддаггүй байна. Иймд багшийг ажлын байранд нь үр дүнтэй тасралтгүй хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ шаардлага манай улсад тулгараад байна. Монгол улсад багшийг ажлын байранд нь тасралтгүй хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгүүдийг гарган хэрэгжүүлж эхлээд байна (БСШУЯ-ны сайдын А803 тоот тушаал, 2019). БСШУС-ын 2019 оны 12 сарын 17-ны өдрийн А/803 тоот тушаал, “Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх журам”-д багшийг хөгжүүлэх, хөгжлийн тогтолцоог сургуулийн орчинд бүрдүүлэх, нийт болоод хувь багшийн мэргэжлийн хэрэгцээ шаардлагыг хангах, багшийн хөгжлийн ахицыг суралцагчийн сурлагын амжилттай уялдуулан хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нь сургуулийн удирдлагын үүрэг болсон байна.

Манай улсад багшийг хөгжүүлэх хүртээмжтэй систем үгүйгээс цөөн суралцагчтай, цөөн багштай сургууль ялангуяа сумын төвийн дунд сургууль, их дээд сургуулийн харьяа дахь гүнзгийрүүлсэн сургалттай ахлах сургуулиудын хувьд долоо хоногийн хичээл заах цагийн ачааллаас хамааран зарим судлагдахууны зөвхөн нэг багш байдаг мөн багшийн заах хичээлийн цаг долоо хоногийн 19 цагийн нормд хүрдэггүй тул өөр төрлийн хичээл заах шаардлага гардаг байна. Ийм сургуулиудын хувьд багшийг ажлын байрнаас гадна урт, богино хугацааны сургалтад хамруулах, сургууль дээр мэргэжлийн хөгжлийн бүлэг үүсгэн ажиллах боломж нь бага байна.

Их дээд сургуулийн харьяа дахь ахлах сургууль нь бага дунд боловсролын тухай хуулийн дагуу хэлбэрийн хувьд төрийн өмчит ахлах сургууль боловч, Боловсрол Шинжлэх ухааны яам (БШУЯ)-наас хэрэгжүүлж буй ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, нийгмийн хангамж зэрэг олон асуудалд тойргийн гадна үлдэх тохиолдол цөөнгүй байдаг.

Багшийг ажлын байранд нь оновчтой үр ашигтай хөгжүүлэх талаар динамик хандлага, загварыг олон улсад баримталж хэрэгжүүлж байгаа онол арга зүйн туршлага цөөнгүй (В. Creemers, L. Kyriakides, P. Antoniou, 2013). Мөн чадвартай багш гэж ямар багш болох талаар, хамгийн сайн багш гэж ямар чадамж, чадвартай хүнийг хэлэх талаар төсөөлөл, загвар олон байдаг байна. Чадвартай багшийн загварыг боловсруулсан олон улс ба монгол улсын судлаачдын жишиг загварууд байдаг (, ЕБС-ийн Зөвлөх багийн багшийн загвар боловсруулах ажлын хэсгийн тайлан, 2012). Сайн багшийн загваруудыг харьцуулан авч үзэхэд багшийн мэдлэг, чадвар, хандлага, мэргэжлийн ёс зүй үнэт зүйл гэсэн үндсэн дөрвөн ойлголтын хүрээнд авч үздэг. Багшийн хөгжлийн динамик загвараар багшийн мэргэжлийн хөгжлийг тасралтгүй хангаж болно. Үүнд багшийн мэргэжлийн хөгжлийн хувийн хэрэгцээг харгалзан үзэж хөтөлбөрийн загварыг төлөвлөх, явцын үнэлгээгээр дахин сайжруулж, дахин үнэлж хэрэгжүүлнэ. Багш бүрийн ур чадвар өөр тул мэргэжлийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа өөр өөр байх боломжтой. Мөн динамик загварын хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан багш нарын суралцагчдын сурлагын амжилтад ахиц гарсан ба багшлах ур чадварын хөгжил нь суралцагчдын сурлагын амжилтад эерэг нөлөө үзүүлж байна (Kyriakides, M. Christoforidou, A. Panayiotou & B.P.M. Creemers, 2017). Иймээс 21 дүгээр зуунд багш ажлын байрандаа мэргэжлээрээ тасралтгүй хөгжих тогтолцоог бүрдүүлж, мэргэжлийн мэдлэг, чадвар, хувь багшийн хандлагын эерэг өөрчлөлт, мэргэжлийн үнэт зүйлийг эрхэмлэн, хөгжих өөрийн хүсэл сонирхол, ёс зүйн төлөвшилд анхаарах шаардлага харагдаж байна.

Сургууль багш нараа хөгжүүлэхийн тулд хувь багшийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад нийцсэн, тухайн сургуулийн эрхэм зорилготой уялдсан, багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх. Нөгөө талаас хэрэглэгч буюу суралцагчдын зүгээс ямар багшийг хүсэн хүлээж байгааг мэдэх нь сургуулийн зүгээс хийх шаардлагатай ажил юм.

Судалгааны зорилго нь “Чадварлаг багш” хөтөлбөрийн хүрээнд Байгаль-Эх лицей ахлах сургууль багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багш нараа ажлын байранд нь чадавхжуулах төлөвлөгөөг боловсруулахад судалгааны үр дүнг тооцох юм. Байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай тус сургуулийн суралцагчид “Сайн багш”-ийн тухай ямар ойлголттойг илрүүлэн, цаашид багшийн чадамжийн ямар үзүүлэлтүүдийг түлхүү хөгжүүлэх хэрэгцээг сургууль анхааран ажиллана.

Зорилгыг биелүүлэх хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан.

- Багш, суралцагчдаас санал асуулга авах,
- Санал асуулгын үр дүнг боловсруулах
- Санал асуулгын боловсруулалтаас үр дүнг дүгнэх
- Сургуулийн багшийн хөгжлийн хөтөлбөр (БХХ), төлөвлөгөөнд судалгааны үр дүнг тооцох, дахин төлөвлөх.

Судалгаагаар сайн багшид байх чадвар чадамж хандлагыг илэрхийлсэн 4 айн 10 үзүүлэлт бүхий хэмжүүрээр суралцагч, багш нараас асуулга авсан. Судалгаагаар сайн багшийн талаарх багш нар, суралцагчдын төсөөллийн ижил ба ялгаатай тал, багшийн талаарх үзэл бодол

суралцагчдын хүйс, нас, гүнзгийрүүлэн судалж буй судлагдахуунаас хамаардаг эсэхийг илрүүлэхийг зорилоо.

Судалгааны арга зүй

Судалгааны арга

Сайн багшийг тодорхойлох нийгэм сэтгэлзүйн, сурган хүмүүжүүлэх-сэтгэл судлалын, ёс суртахуун ба сэтгэл судлалын, танин мэдэхүйн мэдлэг-мэдээлэл гэсэн ерөнхий 4 ангилалтай 10 үзүүлэлт бүхий асуулгаар суралцагчид, багш нараас судалгаа авав (Carmen Rusu, 2011). Багшийн

- Нийгэм сэтгэлзүйн чадамжид: үзүүлэлт 1 (*харилцааны чадамж*), үзүүлэлт 7 (*суралцагчдыг сайн сонсдог байх*),
- Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын чадамжид: үзүүлэлт 2 (*шударга үнэлдэг*), үзүүлэлт 8 (*заасан хичээлд суралцагчид нь дуртай байх*), үзүүлэлт 10 (*бие даан суралцах арга барилыг зааж өгөх чадамжай байх*), үзүүлэлт 4 (*суралцагчдын оюун ухааны хөгжилд дэмжлэг үзүүлдэг байх*), үзүүлэлт 6 (*багш өөрийгөө хөгжүүлдэг байх*)
- Танин мэдэхүй мэдлэг мэдээллийн чадамжид: үзүүлэлт 3 (*зааж буй хичээлээ мэддэг байх*), үзүүлэлт 9 (*хичээл хоорондын интеграц хийх*),
- Ёс суртахуун ба сэтгэл судлалын чадамжид: үзүүлэлт 5 (*бусадтай хүндэтгэлтэй харилцах*) гэсэн үзүүлэлтүүдийг тус тус авч үзсэн.

Судалгаанд мөн БЭЛАС-ийн 21 багш хамрагдсан. Нийт багш нарын 52.4% нь байгалийн ухааны, 47.8% нь нийгмийн ухааны багш. Багш нарын 62.5% нь заах арга зүйч, 37.5% нь тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй. Үүнээс ажилласан жилийн хувьд 26-30 жил, 6-10 жил ажилласан багш нар тус бүр 23.8%-ийг, 20-25 жил, 11-15 жил ажилласан багш нар тус бүр 14.3%-ийг, 16-20 жил, 2-5 жил ажилласан багш нар мөн тус бүр 9.5%-ийг эзэлж байна. Нийт багш нарын 42.9% нь магистр, бакалаврын зэрэгтэй.

Түүврийн бүтэц

МУИС-ийн харьяа Байгаль-Эх лицей ахлах сургууль (БЭЛАС) нь математик байгалийн ухааны (физик, хими, биологи, газарзүй) чиглэлээр гүнзгийрүүлсэн сургалт явуулдаг ахлах сургууль юм. Тус сургуулийн суралцагчид гүнзгийрүүлэн суралцах байгалийн ухааны хичээлүүдээр мөн сонгон суралцдаг. Гүнзгийрүүлсэн сургалтыг МУИС-ийн эрдэмтэн багш нар, сонгон суралцах ба заавал судлах хичээлүүдийг БЭЛАС-ийн үндсэн багш нар заадаг. Тус сургууль нь 10-аас 12-р ангийн нийт 15 бүлэгтэй, 360 гаруй суралцагч, нийт 21 багштай (газарзүй-1, хими-1, технологи дизайн-1, биологи-2, физик-2, математик-4, түүх, нийгэм-3, англи хэл-4, монгол хэл бичиг, уран зохиол-3).

Судалгааг 2021-2022 оны хичээлийн жилийн намрын улиралд, МУИС-ийн Байгаль-Эх лицей ахлах сургуулийн 15-18 насны 319 суралцагчаас санал асуулга хэлбэрээр авав. Судалгаанд хамрагдсан суралцагчдыг насны ангиллаар авч үзвэл 15 настай 140, 16 настай-124, 17 настай 51, 18 настай 4 суралцагч тус тус байв. Гүнзгийрүүлэн суралцдаг бүлгийн хувьд математикийн 125, физикийн 50, химийн 47, биологийн 78, газарзүйн 19 суралцагч тус тус байна. Хүйсийн хувьд эрэгтэй 143, эмэгтэй 176. Судалгаанд нийт суралцагчдын 95 хувь хамрагдсан.

Судалгааны тоон боловсруулалт

Сайн багшийн тухай 10 үзүүлэлтээс суралцагчид хамгийн чухал гэж үзсэн 5 үзүүлэлтийг сонгосон. Суралцагчдын сонголтоор сонгогдсон үзүүлэлтийн давталтын тоо, хувь хэмжээг тооцсон. Сайн багшийн тухай ойлголтыг суралцагчдын сонгосон сонголтын өгөгдөлд нас, хүйс, бүлэг (гүнзгийрүүлэн суралцдаг судлагдахууны чиглэл) -ээс хамааруулан статистик боловсруулалт хийхдээ SPSS 26 программ дээр бүлэг хоорондын ялгааг илрүүлэхээр үл хамаарах t шалгуур, нэг хүчин зүйлийн Anova шинжилгээ хийсэн.

Үр дүн

Байгаль- Эх лицей ахлах сургуулийн суралцагчдаас сайн багшид байх чадамжуудийн талаар асуусан нийт 10 үзүүлэлт бүхий асуулгаар судалгааг авахад Үзүүлэлт 6-ийг зөвхөн нэг суралцагч сонгосон байсан тул тоон боловсруулалтад оруулалгүй хассан.

Дээрх 10 үзүүлэлт тус бүрд үл хамаарах t шалгуурыг бодсоноос хүйсийн хувьд статистик ач холбогдолтой ялгаатай байх дараах хоёр үзүүлэлтийн үр дүнг (Үзүүлэлт 7: “суралцагчдыг сайн сонсдог байх” сонголтод $t(311.4) = -2.225$, $p = 0.027 < 0.05$, үзүүлэлт 8: “заасан хичээлд нь суралцагчид дуртай байх” -ын хувьд $t(293) = -2.010$, $p = 0.045 < 0.05$) Хүснэгт 1-д үзүүлээ. “Багш суралцагчдыг сайн сонсдог байх” үзүүлэлтийг нийт 120 суралцагч сонгосноос 75 нь буюу 62.5% нь эмэгтэй, 45 буюу 37.5% нь эрэгтэй суралцагч байна. Заасан хичээлд нь суралцагчид дуртай байх үзүүлэлтийг 99 суралцагч сонгосноос 54% нь эрэгтэй, 45% нь эмэгтэй байна.

Хүснэгт 1. Сайн багшийн үзүүлэлтийн хүйсийн хувьд t тестийн үр дүн

Үзүүлэлт	Хүйс	t	df	p	Сонголтын		Сонгосон тоо
					Тоо	Хувь (%)	
Суралцагчдыг сайн сонсож чаддаг байх	Эрэгтэй	-2.225	311.4	0.027	45	37.5	120
	Эмэгтэй				75	62.5	
Багшийн заасан хичээлд суралцагч дуртай байх	Эрэгтэй	-2.010	293	0.045	54	54.0	99
	Эмэгтэй				45	45.0	

Сайн багшийг тодорхойлох үзүүлэлтүүдийг суралцагчдын наснаас нь хамааруулан нэг хүчин зүйлийг тодорхойлохын тулд ANOVA шинжилгээг хийсэн (Хүснэгт 2). “Суралцагчдын оюун ухааны хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг байх” үзүүлэлт 4-ийн хувь ($F(3.315) = 4.729$, $p = 0.003 < 0.05$), “суралцагчдыг сайн сонсдог байх” үзүүлэлт 7-гийн хувьд ($F(3.315) = 2.879$, $p = 0.036 < 0.05$), заасан хичээлд суралцагчид дуртай байх үзүүлэлт 8-ын хувьд ($F(3.315) = 3.088$, $p = 0.027 < 0.05$) гэсэн статистик ач холбогдолтой ялгаатай үр дүнтэй байна. Энэ нь суралцагчид анги дэвшиж нас нэмэгдэхэд тэдний суралцах (оюун ухаанаа хөгжүүлэх) үйл ажиллагаанд багшийн дэмжлэг хэрэгтэй гэж үзэх хувь буурч байгааг харуулж байна. Жишээлбэл, үзүүлэлт 4-ийг сонгосон нийт 132 сонголтын 54.5% нь 15 настай, 31% нь 16 настай, 11.3% нь 17 настай байна. Үзүүлэлт 7 (суралцагчдыг сайн сонсдог байх), үзүүлэлт 8 (заасан хичээлд нь суралцагчид дуртай байх)-үүдийн хувьд статистик ач холбогдолтой үр дүн гарсан боловч судалгаанд хамрагдсан 18 настай суралцагчийн тоо нийт түүврийн 1% -ийг эзэлж байгаа тул бүрэн төлөөлөх чадамжгүй гэж үзлээ. Иймээс үзүүлэлт 7, 8-ын хувьд тоон боловсруулалтын үр дүнгээс статистик ач холбогдолтой ялгаа илэрсэн боловч, энэ удаад тооцохгүй орхилоо.

Хүснэгт 2. Сайн багшийн үзүүлэлтүүдэд насны ангиллаар нь Аноva шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	df ₁ , df ₂	F	P	Бүлгийн тоо	А		Б	
					Нас	Хувь (%)	Нас	Хувь (%)
Суралцагчийн оюун ухааны хөгжилд дэмжлэг үзүүлдэг байх	(3,315)	4.729	.003	3	15	54.5	15	54.5
					16	34.0	16	34.0
					17	11.3	17	29.4
Суралцагчдыг сайн сонсох		2.879	.036	2	15	48.3	15	41.0
					16	34.0	16	33.0
					17	14.2	17	33.0
					18	3.50	18	100
Багшийн заасан хичээлд суралцагч дуртай байх		3.088	.027	2	15	55.3	15	37.0
					16	35.0	16	26.0
	17				10.0	17	19.6	
	18				0.00	18	0.00	

Тайлбар:

А: баганад байгаа хувь нь нийт сонголтоос тухайн үзүүлэлтийг сонгосон хувийг илэрхийлнэ.

Б: баганад байгаа хувь нь тухайн үзүүлэлтийг сонгосон 15 настай, 16 настай, 17 настай суралцагчдын тухайн насны ангилал бүрийн хувьд эзлэх хувийг илэрхийлнэ.

Хүснэгт 3. Сайн багшийн үзүүлэлтүүдийг насны ангиллаар нь эзлэх хувийг тооцоолсон үр дүн

Үзүүлэлт	Нийт сонголт тоо	15 настай 140 суралцагч			16 настай 124 суралцагч			17 настай 51 суралцагч		
		Тоо	А %	Б%	Тоо	А %	Б%	Тоо	А %	Б%
Y1	110	55	50.0	39.2	35	31.8	28.2	16	14.5	31.3
Y2	130	54	41.5	38.5	52	40.8	41.9	22	16.9	43.1
Y3	101	50	49.5	35.7	30	29.7	24.1	19	19.9	37.2
Y4	132	72	54.5	51.0	41	31.0	33.0	15	11.3	29.4
Y5	55	23	41.8	16.4	25	31.6	20.0	6	11.0	11.7
Y7	120	58	48.3	41.0	41	34.0	33.0	17	14.2	33.3
Y8	94	52	55.3	37.1	33	35.0	26.6	10	10.0	19.6
Y9	90	45	50.0	32.0	29	32.0	23.3	13	14.4	25.4
Y10	97	52	53.6	37.0	32	33.0	25.8	13	13.4	25.4

Тайлбар:

А баганад байгаа хувь нь тухайн үзүүлэлтийг сонгосон нийт сонголтоос эзлэх хувийг илэрхийлнэ.

Б баганад байгаа хувь нь тухайн үзүүлэлтийг сонгосон 15 настай, 16 настай, 17 настай суралцагчдын тухайн насны ангиллаасаа эзлэх хувийг илэрхийлнэ.

Y1: үзүүлэлт1 (Харилцааны чадамжтай байх) гэх мэт сайн багшид байх чадамжийн үзүүлэлтийг кодолсон.

Сайн багшийг тодорхойлох үзүүлэлтүүдийг бүлэг (суралцагчдын гүнзгийрүүлэн суралцах судлагдахуунаас)-ээс хамааруулан нэг хүчин зүйлийн ANOVA шинжилгээ хийв. Судалгаанд 319 суралцагч (математик-125, физик-50, хими-47, биологи-79, газарзүй-18) хамрагдсан. Үзүүлэлт 8 (заасан хичээлд нь суралцагчид дуртай байх)-ын хувьд бүлэг хоорондын хамаарал ($p=0.002<0.05$) статистик ач холбогдолтой ялгаатай үр дүн гарсан. Яг ямар бүлгийн хувьд ялгаатай байгааг post hoc шинжилгээ хийж үзэхэд химийн анги, математикийн ангиас сайн багшийн талаарх үзүүлэлт 8-ийн хувьд ялгаатай байна.

Үзүүлэлт 8 (заасан хичээлд нь суралцагчид дуртай байх) -ыг сонгосон сонголтын тоо 94. Үүнээс химийн ангийн хүүхэд 5 байгаа нийт сонголтын 5.3%, энэ нь химийн ангийнхаа 10.6%-

ийг эзэлж байна. Үзүүлэлт 8-ыг сонгосон математикийн ангийн суралцагчдын тоо 47 байгаа нь нийт сонголтын 50% байна энэ нь математикийн ангийн 37.5% юм.

Хүснэгт 4. Сайн багшийн үзүүлэлтийг суралцагчдын гүнзгийрүүлэн суралцдаг судлагдахуунаас нь хамааруулан Anova шинжилгээ хийсэн үр дүн

Үзүүлэлт	df	F	P	Бүлгийн тоо	Эзлэх хувь
Багшийн заасан хичээлд суралцагчид дуртай байх	318	2.772	0.027	2	Химийн анги – (нийт сонголтын) 5.3%, тухайн ангийн 10.6% Математик анги (нийт сонголтын) 50.3%, тухайн ангийн 37.5%

Гүнзгийрүүлэн судлах анги тус бүрээс хамрагдсан суралцагчийн тоог судлагдахууны хамт Хүснэгт 5-д тусгасан.

Хүснэгт 5. Сайн багшийн үзүүлэлтүүдийг сонгосон судлагдахуунаас хамаарсан эзлэх хувь

Үзүүлэлт	Нийт сонголтын тоо	Математик- 125			Физик-50			Хими-47			Биологи-79			Газарзүй-18		
		Тоо	A%	B%	Тоо	A%	B%	Тоо	A%	B%	Тоо	A%	B%	Тоо	A%	B%
Y1	110	43	39	34	22	20	44	13	12	28	28	25	35	3	3	15
Y2	130	50	38	40	22	17	44	16	12	34	33	25	42	9	7	47
Y3	101	36	35	29	22	22	44	11	11	23	26	26	33	6	6	31
Y4	132	53	40	42	25	19	50	14	10	30	31	24	66	8	6	42
Y5	55	25	46	20	7	13	14	10	18	21	13	24	28	0	0	0
Y7	120	52	43	42	20	17	40	16	13	34	25	21	53	7	6	36
Y8	94	47	50	38	14	15	3	5	5	11	25	27	53	4	4	21
Y9	90	34	38	27	14	16	3	9	10	19	29	32	37	4	4	21
Y10	97	41	42	33	17	18	17	12	12	26	24	24	30	5	5	26

Тайлбар:

A баганад байгаа хувь нь тухайн үзүүлэлтийг сонгосон нийт сонголтоос эзлэх хувийг илэрхийлнэ.

B баганад байгаа хувь нь тухайн үзүүлэлтийг сонгосон бүлгээс эзлэх хувийг илэрхийлнэ

Y1: үзүүлэлт1 (Харилцааны чадамжтай байх) гэх мэт сайн багшид байх чадамжийн үзүүлэлтийг кодлосон

БЭЛАС-ийн суралцагчдын хувьд “Сайн багш” гэдэг нь математик, химийн ангийнхны хувьд суралцагчдыг сайн сонсдог байх, физик, биологийн ангийнхны хувьд тэдний оюун ухааныг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж чаддаг байх, хими ба газарзүйн ангийнхны хувьд шударга үнэлдэг байх нь хамгийн чухал үзүүлэлт байна.

Санал асуулгад оролцсон суралцагчдын сайн багшийг тодорхойлох 10 үзүүлэлтээс сонгосон эхний 5 үзүүлэлтэд өндөр хувьтай нь

- үзүүлэлт 4 (суралцагчдын оюун ухааны хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг байх) – 41.4%,
- үзүүлэлт 2 (шударга үнэлгээ)- 40.7%,
- үзүүлэлт 7 (суралцагчдыг сайн сонсдог байх)- 37.6%,
- үзүүлэлт 1 (харилцааны чадамж)- 34.4%,
- үзүүлэлт 5 (зааж буй хичээлээ мэддэг байх)- 31.6%-тай байна.

Эндээс харвал суралцагчид багшийг сурган хүмүүжүүлэх ба сэтгэл судлалын талаар илүү чадамжтай байхыг хүсэж байна. Харин багшийн ёс суртахууны талаар (17.2%) төдийлөн шаардлага тавихгүй байгаа нь тус сургуулийн багш нарт ёс зүйн асуудал төдийлөн гардаггүйг харуулж байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Сайн багшийн тухай ойлголтыг тодорхойлох

4 айн хувьд нийт сонголтын эзлэх хувь

Нийгэм сэтгэлзүйн	Сурган хүмүүжүүлэх ухаан ба сэтгэл судлал	Танин мэдэхүй, мэдлэг мэдээлэл	Ёс суртахуун ба сэтгэл судлал
34.4%	35.4%	30.0%	0.2%

Сайн багшийн тухай суралцагчдын ойлголтыг тэдэнд хичээл зааж байгаа багш нараас санал асуусан дүнг Хүснэгт 7-д үзүүлээ. Багш нарын хувьд сайн багш байхын тулд зааж буй хичээлээ илүү сайн мэддэг байхыг хэлж байна. Үүнийг суралцагчдын санал асуулгын дүнг үзүүлсэн Сайн багшид байх харилцааны чадамж, сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын чадамжууд нь мэдлэгээс илүү чухлаар авч үзэж байна. Сонгосон хувийн үр дүнгээс бичнэ.

Хүснэгт 7. Багш нараас авсан санал асуулгын дүн

№	Сайн багшийн үзүүлэлт	Сонголт тоо	Эзлэх хувь (%)
1	Шударга үнэлгээ (Үзүүлэлт 2)	17	81.0
2	Зааж буй хичээлээ мэддэг байх (үзүүлэлт 3)	15	71.4
3	Суралцагчийн оюун ухааны хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг байх (үзүүлэлт 4)	13	61.9
4	Харилцааны чадамж (Үзүүлэлт 1)	11	52.4
5	Хичээл хоорондын интеграц хийх чадамжтай байх (үзүүлэлт 9)	9	42.9
6	Зааж буй хичээлд нь суралцагчид дуртай байх (үзүүлэлт 8)	5	23.8
7	Суралцагчдыг сайн сонсдог байх (үзүүлэлт 7)	2	9.5

Хүснэгт 7 дахь үр дүнгээс харахад багшийн хувьд суралцагчдыг шударга үнэлэх, зааж буй хичээлийн агуулгын мэдлэг, өөрийгөө мэргэжлээрээ тасралтгүй хөгжүүлэх, суралцагчдын оюун ухааныг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж чаддаг байх, суралцагчдыг бие даан суралцах арга барилд сургах чадвартай байх зэрэг үзүүлэлтүүд нэн чухал гэж үзэж байна.

Хэлэлцүүлэг ба дүгнэлт

“Сайн багш”-ийг тодорхойлох 4 айн 10 үзүүлэлтээр БЭЛАС-ийн 10-12 дугаар ангийн 319 суралцагчдаас авсан асуулга судалгаагаар багшийн тухай суралцагчдын үзэл бодол нас, хүйс, суралцаж буй бүлгийн хувьд ялгаатай үр дүнтэй байна.

1. Насны хувьд ANOVA шинжилгээ хийхэд дараах үзүүлэлтүүдийн хувьд статистик ач холбогдолтой ялгаа илэрсэн.
 - a. Суралцагчдын оюун ухааны хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг байх үзүүлэлтийн хувьд ($F(3.315)=4.729, p=0.003 < 0.05$)
 - b. Суралцагчдыг сайн сонсдог байх үзүүлэлтийн хувьд ($F(3.315)=2.879, p=0.036 < 0.05$)
 - c. Багшийн заасан хичээлд суралцагчид дуртай байх үзүүлэлтийн хувьд ($F(3.315)=3.088, p=0.027 < 0.05$)

Дээрх үзүүлэлтүүдийн сонголтын хувийг Хүснэгт 5-аас дэлгэрүүлэн харахад анги ахих тусам суралцагчдын суралцах үйл ажиллагаандаа багшаас авах дэмжлэг багассан үр дүн

гарсан. Суралцагчдыг багш сайн сонсдог байх үзүүлэлт тогтмол хувьтай байгаа нь суралцагчдын хувьд тэднийг багш сайн сонсож харилцах нь чухал үзүүлэлт юм.

2. Хүйсийн хувьд t шалгуурын үр дүнгээр дараах үзүүлэлтүүдэд статистик ач холбогдолтой ялгаа илэрсэн.
 - a. Багш суралцагчдыг сайн сонсдог байх үзүүлэлтийн хувьд ($t(311.4) = -2.225, p = 0.027 < 0.05$), сонголтын хувь эмэгтэй 62.5%, эрэгтэй 37.5% байгаа нь охид хөвгүүдээс илүү “сайн багш” нь суралцагчдыг сайн сонсож харилцах хэрэгтэй гэж үзэж байна.
 - b. Багшийн заасан хичээлд нь суралцагчид дуртай байх үзүүлэлтийн хувьд ($t(293) = -2.010, p = 0.045 < 0.05$), эрэгтэй 54%, эмэгтэй 45% байгаа нь охидыг бодвол хөвгүүдэд багшийн зааж буй хичээл тэдний сонирхлыг татдаг байх нь илүү чухал.

Сургалтын үйл ажиллагаанд охид хөвгүүдийн багшаас харилцааны ялгаатай байдлыг хүсдэг, мөн багшийн бэлтгэсэн хичээлийн хэлбэр, даалгавар суралцагчдын сонирхолд нийцсэн, хэрэгцээг хангахад чиглэж байхаар төлөвлөж чадаж байгаад сургууль анхаарал хандуулж багшийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
3. Суралцагчдын гүнзгийрүүлэн суралцдаг бүлгээс хамааруулан нэг хүчин зүйлийн ANOVA шинжилгээ хийхэд заасан хичээлд нь суралцагчид дуртай байх үзүүлэлтийн хувьд ($p=0.027<0.05$) статистик ач холбогдолтой ялгаатай байна.
4. Аль бүлэг хооронд ялгаа байгааг post hoc шинжилгээгээр шинжлэхэд хими, математикийн анги хооронд ялгаа илэрсэн. Бүлгийн хувьд нэг хүчин зүйлийн шинжилгээний үр дүнг харахад математикийн хичээлийг суралцагчдад сонирхолтой байдлаар заах, мөн математикийн багшийн сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах арга зүйг хөгжүүлэх шаардлагатай, эсвэл математик, химийн хичээлээр гүнзгийрүүлэн суралцаж байгаа суралцагчдын хооронд “сайн багшийн тухай” үзэл бодлын ялгаа үүсэж байгаа нь математик, химийн хичээл тус бүр гүнзгийрүүлэн суралцдаг суралцагчдын онцлогоос хамаарч байх магадлалтай.
5. Багшаас авсан санал асуулгын дүнг суралцагчдынхтай харьцуулан авч үзэхэд суралцагчдад хамгийн чухал үзүүлэлт нь тэдний суралцах, оюун ухааны хөгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж чаддаг байх, харин багш нарын хувьд суралцагчдыг шударга үнэлэх нь чухал гэж үзсэн. Энд багш суралцагчдын сайн багшийн тухай үзэл бодлын зөрүү байдаг нь харагдаж байна.
6. “Суралцагчдыг сайн сонсдог байх” үзүүлэлт суралцагчдын сайн багшид байх хамгийн чухал эхний 3 сонголтод багтаж байхад, харин багш нарын хувьд энэ үзүүлэлт төдийлөн чухал гэж үзээгүй (багш -9.5%, суралцагч- 38%). Багш суралцагчийн үзэл бодлын энэ зөрүү сургалтын үйл ажиллагаанд багш нь суралцагчийг мэдэрч ойлгон харилцах, тэдний үзэл бодлыг сонсох хэрэгцээ байгааг харуулж байна.
7. Судалгааны үр дүнгээс харахад Байгаль-Эх лицей ахлах сургуулийн Багшийн Мэргэжлийн Хөгжлийн Хөтөлбөр боловсруулахад багшлах аргазүй, суралцагчдыг үнэлэх талаар сургалт, туршлага солилцох үйл ажиллагааг төлөвлөнө. Мөн суралцагчтай харилцах харилцааны чадамж, суралцагчдад сэтгэлзүйн зөвлөмж өгөх, суралцах үйл ажиллагааг дэмжин ажиллах чиглэлийн чадамжтай болгох үйл ажиллагааг төлөвлөнө.

Талархал

Энэхүү судалгаанд хамрагдсан Байгаль-Эх лицей ахлах сургуулийн суралцагчид, багш нар, судалгааны үйл ажиллагааг дэмжин ажилласан сургуулийн захиргаанд талархал илэрхийлье.

Ном зүй

- ЕБС-ийн Зөвлөх багийн багшийн загвар боловсруулах ажлын хэсгийн тайлан. (2012). 21-р зууны монгол багшийн загвар. Улаанбаатар хот.
- В. Creemers, L. Kyriakides, P. Antoniou. (2013). Teacher professional development for improving quality of teaching. New York, London: Springer.
- Carmen Rusu, L. S. (2011) PCIWORD.. procedia-Social and Behavioral Sciences 33 (2012) 1017-1021, ELSEVIER. "The ideal teacher theoretical and investigativa approach"
- Kyriakides, M. Christoforidou, A. Panayiotou & B.P.M. Creemers. European journal of teacher education, (2017). vol 40, NO. 4, 465-486 "The impact of the three- year teacher professional development course on quality of teaching: strengths and limitations of the dynamic approach.
- OECD. (2010). Teacher development framework.
- БСШУЯ. (2019). Монгол улсын суурь мэдээллийн тайлан. Улаанбаатар хот.
- БСШУЯ. (2020). Алсын хараа-2050. In Боловсролын салбарт эрх тэгш байдал, үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх нь (р. 51). Улаанбаатар хот.
- БСШУЯ. (2020). Алсын хараа-2050. In Боловсролын салбарт тэгш эрх, үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх (р. 51). Улаанбаатар хот.
- БСШУЯ-ны сайдын А803 тоот тушаал. (2019). ЕБС, СӨБ-ийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх журам. Улаанбаатар хот.
- УИХ. (2002). Бага дунд боловсролын тухай хууль. Улаанбаатар хот: 6-р бүлэг 21-р зүйл.
- УИХ. (2018). Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль. Улаанбаатар хот.

1-3-ДУГААР АНГИЙН МАТЕМАТИКИЙН СУРАХ БИЧГИЙН ДААЛГАВРЫН ШИНЖИЛГЭЭ

Д.Түмэнбаяр¹, Б.Отгонжаргал², Х.Ганчимэг³

¹ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Математикийн Тэнхим

² НЕБ-ын 84-р сургууль, Математикийн багш

³ Математикийн Цаг сонин

tumenbayar@num.edu.mn, otgoo.bays1231@gmail.com, ganchimeg9506@gmail.com

Хураангуй

Сурах бичгийн агуулгын хүрээ, залгамж холбоо, арга зүйн боловсруулалт, дасгал даалгаврын тавил, зохиомж, зураг дүрслэл сургалтын хөтөлбөртэй нягт уялдсан байх нь түүний хэрэгжилт, суралцагчийн сурлагын амжилтад эергээр нөлөөлдөг. Тиймээс сурах бичгийн даалгавар нь “сурагчдын танин мэдэх арга, судалж буй сэдвийн талаарх тэдний бодлыг хязгаарлах эсвэл өргөжүүлэхэд нөлөөлөх боломжтой. Энэхүү судалгааны зорилго нь Монголын ЕБС-ийн 1-3 дугаар ангийн математикийн сурах бичгийн даалгавруудын хувьд математик үйл ажиллагаа, танин мэдэхүйн хүндрэлийн түвшин, хариултын хэлбэр болон контекст шинж чанараар нь ангилж, ерөнхий дүр зургийг судалсан. Гурван судлаач 1-р ангийн сурах бичгийн 188 даалгавар, 2-р ангийн сурах бичгийн 652 даалгавар, 3-р ангийн 775 даалгаврыг тус бүр кодлон, үнэлэгч хоорондын найдвартай байдлыг шалгаж, дискриптив статистикийн үр дүнг боловсруулсан. Үр дүнгээс харвал 1-3 дугаар ангийн математикийн сурах бичигт дүрслэх илэрхийлэх, тооцоолох төрлийн даалгавар зонхилж, 2-3 дугаар ангид тайлбарлах төрлийн даалгавар бага хувиар нэмэгдэж орсон боловч няцаах эсвэл үндэслэх, нотлох төрлийн даалгавар багтаагүй байна. Танин мэдэхүйн хүндрэлийн хувьд 1 дүгээр түвшний даалгавар зонхилсон буюу аль ч ангид үндсэн мэдлэг, чадварыг шууд хэрэглэн гүйцэтгэх төрлийн даалгавар дийлэнх байна. Даалгаврын хариултын хэлбэрийн хувьд хаалттай хариулттай даалгавар зонхилж, нээлттэй хариулттай даалгавар маш цөөнийг багтаажээ. 1 дүгээр ангийн математикийн сурах бичигт бодит контексттэй даалгавар огт байхгүй, 2 болон 3-р ангид маш цөөн тоогоор багтжээ. Бодит контексттэй даалгаврын хувьд эх сурвалжийг дурдаагүй байх тохиолдол их байна.

Түлхүүр үг: сурах бичиг, даалгавар, математик үйл ажиллагаа, танин мэдэхүйн хүндрэлийн түвшин, хариултын хэлбэр, контекст шинж чанар

Удиртгал

Сурах бичиг нь математикийн хичээлд чухал үүрэг гүйцэтгэдэг. Бусад улс орнуудын туршлага, судалгааны үр дүнгээр “сурах бичгийн даалгаврууд нь сурагчид оюуны үйл ажиллагаа эхлүүлэх гол эх сурвалж” гэж үзжээ (Fan, 2013). Сурах бичгийн даалгаврын мөн чанар нь "тухайн сэдвийн талаарх мэдлэгийг сурагчдад өгөх, тухайн мэдлэгийг өргөжүүлэх, сурагчдын танин мэдэх, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, зохион байгуулалттай болгоход" оршино. Анги танхимд хэрэглэж буй математикийн сурах бичиг болон бусад сургалтын материалын даалгаврууд баялаг бөгөөд үнэ цэнтэй байх нь чухал гэж судлаачид үзэж байна. Сурах бичигт орсон жишээ, даалгаврыг сурагчид ангидаа эсвэл гэрийн даалгавар хийхдээ өргөнөөр ашигладаг тул математикийн ухагдахуун, шинж чанар, зүй тогтлыг ойлгоход нөлөөлж, сурагчдын анхаарлыг татах, сонирхоход түлхэц болж сурагчдыг оюуны идэвхтэй үйл ажиллагаанд уриалан, цааш гүнзгийрүүлэн судлах сэдэл өгдөг байх ёстой.

Монголын математикийн сурах бичиг даалгаврын судалгааг одоогийн байдлаар хангалттай түвшинд хийгээгүй байна. Энэхүү судалгааны хүрээнд бага боловсролын математикийн сурах бичгийн даалгавар ямар бүтэцтэй байгааг судлах зорилготой.

Сэдвийн судлагдсан байдал

Сурах бичгийн судалгаа нь боловсрол судлалд судалгааны шинэ талбар болон хүч түрэн орж ирж байна. Олон улсад сурах бичгийн дизайн, сурах бичгийн ашиглалтын талаар, уламжлалт буюу хэвлэмэл сурах бичиг болон цахим сурах бичгийн ялгааг тодорхойлох гэсэн чиглэлүүдээр олон талаас судалгаа шинжилгээ хийж байна. Математикийн сурах бичгийн судалгааны чухал нэг хэсэг нь даалгаврын шинжилгээ юм.

Математикийн хичээл нь тухайн улс орны соёл, хэл, ёс заншлаас үл хамааран сургалтын хөтөлбөртэй нягт хамааралтайгаар явагдах ёстой ба ямар хэлээр, хаана зааж байгаагаас үл хамааран үнэн байх ёстой. Сурагчдын гүйцэтгэлийг сайжруулах, математикийн хичээлд дуртай болгох, сонирхлыг төрүүлэх гэсэн асуудал нь сургалтын хөтөлбөр болон сурах бичигт тасралтгүй судалгаа хийж сайжруулах хэрэгцээ шаардлагыг бий болгосон (Yeping & Glenda, 2014). Математикийн сурах бичиг нь тухайн улсын математикийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэгч болдог. 2007 онд Австри улсад сурах бичгийн даалгаврыг шинжлэх 3D хүрээг бий болгосон. Энэ хүрээ нь математик агуулга, математик үйл ажиллагаа, танин мэдэхүйн хүндрэлийн түвшин гэсэн гурван хэмжээсийг багтаасан юм. 2006 онд АНУ болон Хятад улсын сурах бичгүүдийн контекст шинж чанар, болон даалгаврын хариултын хэлбэрийг шинжилсэн судалгаа хийгдсэн (Zhu & Fan, 2006). Мөн Хорват улс эдгээр таван хэмжээсийг нэгтгэж сурах бичгийн даалгавруудаа шинжилсэн байна. Хорватын сургалтанд хамгийн түгээмэл хэрэглэгддэг сурах бичгүүдийг судалгаандаа авч хэрэглэсэн бөгөөд судалгаанд 6, 7, 8-р ангийн математикийн сурах бичгүүдийн 22,000 гаруй даалгаврыг багтаан шинжилжээ. Уг судалгаагаар сурах бичигт даалгаврын олон төрлийн багтааж чадаагүй нь нотлогдсон. Тооцоолох үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгсөн ба тайлбарлах үйл ажиллагаа, эргэцүүлэн бодох сэтгэлгээ, нээлттэй хариултын даалгаврууд дутуу байжээ. Энэ нь өмнө дурдсанчлан математикийн сурах бичгийн даалгаврууд баялаг байж сурагчдыг оюуны идэвхтэй олон талт үйл ажиллагаанд уриалж чадахгүй байна гэж дүгнэхэд хүргэжээ (Glasnovic Gracin & Domovic, 2009). Сурах бичгийн даалгавар нь олон талт үйл ажиллагааг багтаасан байх ёстой. Даалгаврын төрөл, хэлбэрүүдийн тэнцвэртэй багтаасан сайн сурах бичиг гэдэг нь математик үйл ажиллагаа, математик агуулга, танин мэдэхүйн хүндрэлийн түвшин, хариултын хэлбэр, контекст шинж чанар зэрэг таван хэмжээст хүрээг оновчтой тусгасан байхыг хэлнэ.

Судлаач Ли Хятад болон АНУ-ын 7-р ангийн сурах бичгийн бүхэл тооны нэмэх хасах үйлдэл сэдвийн даалгавруудыг харьцуулсан ба судалгааны үр дүнгээр "тооцоолох" үйл ажиллагаа давамгайлсан цэвэр математикийн контексттэй даалгавруудтай гэсэн дүгнэлтэд хүрчээ. Сайн сурах бичиг нь сурагчдын математикийн боловсролыг дээшлүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. TIMSS -ийн болон бусад сурах бичгийн болон хөтөлбөрийн судалгааны үр дүнгээс харахад сурагчид математикийн хичээлд дур сонирхолгүй, сөрөг хандлагатай байгааг тогтоосон. Дунд сургуулийн математикийн хөтөлбөр нь сорилт багатай, олон давтагдсан даалгавраас бүрдсэн гэж үзжээ. Үүний үр дүнд тэдний амжилт, математикийн хичээлд дурлах, сонирхох нь зогсонги байдалд ордог бөгөөд ирээдүйд эрдэм шинжилгээний болон ажил мэргэжлийн бүх боломжуудыг ашиглах боломжгүй байдалд хүрч байгаа юм. Жу болон Фин нар АНУ, Хятад улсуудын дунд сургуулийн математикийн сурах бичгийн даалгаврыг шинжилсэн ба бодит байдлаас хийсвэрлэсэн контекст шинж чанартай, хаалттай хариултын хэлбэртэй даалгаврууд зонхилж байв (Zhu & Fan, 2006).

2.1. Сурах бичгийн даалгаврын шинжилгээ

Ерөнхийдөө сурах бичгийн даалгаврууд нь "үйл ажиллагаа эхлүүлэх" гол хэрэгсэл гэж тооцогддог. Судлаач Стенмарк сурах бичгийн даалгаврууд "баялаг" даалгавар байх ёстой гэж үзжээ. Баялаг даалгавар нь

- Сургалтын хөтөлбөрт заагдсан агуулгыг багтаасан байх
- Бодит амьдралд ойр, хэрэглээний даалгавруудтай байх
- Өөр асуудлууд руу хөтөлдөг байх
- Сурагчдыг танин мэдэхүйн идэвхтэй үйл ажиллагаанд уриалсан байх
- Сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх
- Танин мэдэхүйн өөр өөр чадваруудыг хөгжүүлэхүйц байх
- Олон хариулт шаардах эсвэл олон арга барилаар шийдэгдэхүйц байх

гэх мэт шинж чанарыг хангасан байвал зохистой (Stenmark, 1991).

Винсент, Стейси нар ахлах болон бага сургуулийн сурагчдын хувьд даалгаврын тэнцвэрт байдал нь өөр өөр байх ёстой гэж үзсэн ба сурагчид бүх төрлийн бодлогыг боддог байх шаардлагатай гэсэн байдаг. (Vincent & Stacey, 2008). Математикийн хичээлд бусад сургалтын материал ашиглагддаг ч сурах бичиг хамгийн их хэрэглэгддэг байна. Шинэхэн заасан томьёо тодорхойлолтыг шууд ашиглан гүйцэтгэх даалгавар болон цээжлэх төрлүүдийг нэгдүгээр түвшний даалгаврууд гэж үзэх бол "ойлгох, тайлбарлах, мэдлэг, ур чадвараа уян хатан ашиглах, хэд хэдэн өөр эх сурвалжаас мэдээлэл цуглуулах" зэрэг үйл ажиллагааг хийж байвал энэ нь дээд түвшний даалгаврууд гэж нэрлэгдэнэ. Кейтел сурах бичгийн хамгийн чухал зүйл бол даалгаврын чанар, ялгаатай байдал гэж үздэг. Ихэнх сурах бичгүүд "Дүрэм-Жишээ-Дадлага" гэсэн бүтэцтэй байдаг. Лав, Пимм нар математикийн сурах бичгүүдийн текстийг цэгцлэх хамгийн түгээмэл арга бол "Үзүүлэн-Жишээ-Дасгалын загвар" гэж үзсэн (Love & Pimm, 1996). Жишээ нь сурагчдад дараагийн даалгаврыг ажиллах загварыг өгөхийг хэлнэ. Дасгалууд нь сурагчдын хийх ёстой төрөл бүрийн даалгавруудыг хэлдэг бөгөөд ингэснээр текстийн идэвхтэй уншигчид нь сурагчид байх ёстой болно. Тиймээс уншигчдад ойлгомжтой, мэдлэгээ өөрөө бүтээхэд туслах гол хэрэгсэл нь сурах бичиг бөгөөд өөрийгөө хөгжүүлэх, дадлагажуулах хэрэгсэл нь болох ёстой.

2.2. Математик үйл ажиллагаа

Математик үйл ажиллагаа нь дараах дөрвөн (Н1, Н2, Н3, Н4) хэмжээсээс бүрдэнэ.

Дүрслэх, илэрхийлэх (Н1) төрлийн даалгавар нь өгөгдсөн математикийн өгөгдлийг өөр математик дүрслэл болгон "хөрвүүлэх" бодлогууд хамаарах бөгөөд нэг статистик дүрслэлээс нөгөөд шилжүүлэх, хүснэгтээс диаграмм график байгуулах, томъёо ашиглан хүснэгт байгуулах гэх мэт багтана.

Тооцоолох (Н2) төрлийн даалгавар нь энгийн тооцоолол хийх үйлдлүүдийг хэлэх бөгөөд хэмжүүрийн нэгжийг хувиргах, математик илэрхийллийг хувиргах, тэгшитгэлийг шийдвэрлэх, үр дүнг тооцох, тоймлох, энгийн геометрийн байгуулалт зэргийг багтаана.

Тайлбарлах (Н3) төрлийн даалгавар нь математик дүрслэлд (график, тэмдэг тэмдэглэгээ болон хүснэгт) өгөгдсөн харилцаа холбоо, холбогдох өгөгдлийг таних, өгөгдсөн контекстэд тохирсон тайлбар хийхийг хэлнэ. Тайлбарлах нь график эсвэл математик тэмдэг тэмдэглэгээ, дүрслэлийг зохих ёсоор зөв уншиж, тэдгээрийг тухайн нөхцөл байдалд тайлбарлах явдал юм.

Няцаах ба үндэслэх нотлох (Н4) төрлийн даалгавар нь тодорхой дүгнэлтийн эсрэг эсвэл дүгнэлтийг дэмжсэн математик тайлбар гаргахыг хэлнэ. Энэ нь математикийн зүй тогтол, чанарыг тодорхой бөгөөд зохистой хэрэглэх, математик дүрмийг, түүнчлэн математик хэлийг зөв ашиглахыг шаарддаг. Үндэслэл нь дүгнэлт хийхэд хүргэдэг үнэн аргуудын дараалалд хамаарна.

2.3. Танин мэдэхүйн хүндрэлийн түвшин

Математикийн зарим даалгавар нь ижил үйл ажиллагаатай байж болох ч танин мэдэхүйн хүндрэлийн түвшин нь ялгаатай байдаг. Сурах бичгийн даалгавруудын танин мэдэхүйн хүндрэлийг бага, дунд, хүнд гэж гурав (K1, K2, K3) ангилж болно.

1 дүгээр түвшний (K1) даалгавар нь үндсэн мэдлэг, ур чадварыг шууд хэрэглэх бодлогууд багтана. Жишээ нь: 0.35 бутархайг энгийн бутархай болго.

2 дугаар түвшний (K2) даалгаварт өөр өөр математик ухагдахууныг холбож бодолт хийх даалгаврууд багтана. Жишээ нь: 1 литрийн багтаамжтай савны $\frac{1}{8}$ хэсэгт сүү хийв. Саван дахь сүүний өндрийг тэмдэглэ.

3 дугаар түвшний (K3) даалгавар нь математикийн талаарх бүтээлч мэдлэгийг хэрэгжүүлэх, эргэцүүлэн бодох үйл ажиллагаа шаардагдах бодлогууд хамаарна. Жишээ нь: Заримдаа рационал тоог хүмүүс энгийн бутархайгаар эсвэл аравтын бутархайгаар илэрхийлэх нь тохиромжтой байдаг. Ямар үед энгийн бутархайг ашиглах, ямар үед аравтын бутархайг ашиглах вэ? Хоёр жишээ гаргаж, хариултаа тайлбарлаарай.

2.4. Хариултын хэлбэр

Даалгаврын хариултын хэлбэрийг дараах гурван (A1, A2, A3) ангиллаар авч үзэж болно.

Хаалттай (A1) буюу цор ганц зөв хариулт шаардах богино хариултууд байна.

Нээлттэй (A2) буюу олон төрлийн зөв хариултууд сурагчдаас ирж болно.

Олон сонголттой (A3) буюу холбох хариулт, төстийн хариултуудыг багтааж үзнэ.

Хаалттай хариулттай даалгаврын жишээ: $2x - 6 = 7$ тэгшитгэлийг бод гэсэн даалгавар $x = 6.5$ гэсэн богино зөв хариултыг шаардаж байгаа тул хаалттай хариултын төрөлд орох юм.

Нээлттэй хариулттай даалгаврын жишээ: $2x - 6 = 7$ тэгшитгэлээр шийдэгдэх амьдрал ахуйтай холбоотой өгүүлбэртэй бодлого зохио. Энэхүү даалгаврыг гүйцэтгэхийн тулд сурагчид янз бүрийн хариултууд ирүүлэх тул үүнийг нээлттэй хариулттай гэж үзнэ.

Олон сонголттой хариулт нь тест хэлбэртэй буюу хязгаарлагдмал тооны хариултаас зөв хариултыг сонгох явдлыг хэлнэ. Мөн тохируулан холбох даалгаврыг энэ төрөлд багтааж үзнэ.

2.5. Контекст шинж чанар

Контекст шинж чанар нь сурах бичигт амьдрал ахуйн асуудал шийдвэрлэх даалгавруудад хэр хэмжээгээр, ямар аргаар тусгаж байгааг илэрхийлдэг. Дараах байдлаар гурав (C1, C2, C3) ангилна.

Цэвэр математикийн контекст (C1): Цэвэр математик үг хэллэг, тэмдэг тэмдэглэгээ ашигласан контексттэй даалгаврууд багтана. Жишээлбэл: 0.6 бутархайг процентоор илэрхийл.

Зохиомол контекст (C2): Бодит байдлаас сэдэвлэн хийсвэрлэн зохиогдсон даалгаврууд ба энэ төрөл нь зохиогчийн үг хэллэгийг ашигласан байна. Жишээлбэл: Сурагч нэг дэх өдрийн 3-4 цагийн хооронд сургуулийн өмнөөс 12 машин, 4 мотоцикл, 3 фургон хөдөлснийг тоолжээ. Эдгээрийг давтамжийн хүснэгтээр илэрхийл.

Бодит контекст (C3): Даалгаврын нөхцөл байдлыг бодит байдлаас авсан эсвэл сурагчийн бодит туршлага амьдралаас урган гарсан байх даалгаврууд юм. Жишээлбэл: Үдээс өмнө сургуулийнхаа гаднаас хөдөлж буй машинуудыг тэмдэглэн авч, мотоцикл, суудлын машин, автобус гэх мэтээр ангилан давтамжийн хүснэгт зохио.

Судалгааны Арга зүй

Судалгааны түүвэр: 2020 онд шинэчлэгдэн хэвлэгдсэн Математик I, II, III сурах бичгийн даалгавруудыг шинжиллээ. Сурах бичгийн даалгаврын хэсэгт даалгавар болгон дугаарласан бодолттой жишээнүүдийг хасаж тооцов. 1-р ангийн сурах бичгийн 133 даалгавар, 2-р ангийн сурах бичгийн 649 даалгавар, 3-р ангийн 781 даалгаварт дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны өгөгдөл цуглуулах арга зүй: Даалгавруудыг дөрвөн хэмжээс тус бүрээр ангилж, кодолсон. Тухайлбал, математик үйл ажиллагаа, танин мэдэхүйн хүндрэлийн түвшин, хариултын хэлбэр, контекст шинж чанар гэсэн хэмжээсүүдийг багтаав.

Математик үйл ажиллагаа нь дүрслэх илэрхийлэх, тооцоолох, тайлбарлах, батлах гэсэн үндсэн дөрвөн үйл ажиллагаанаас бүрдэнэ гэж онолын хүрээнд багтаасан. Тэгвэл сурах бичгийн даалгаврууд олон үйл ажиллагаа шаардах боломжтой тул аль үйл ажиллагаа илүү давамгайлна түүгээр тухайн даалгаврыг кодлов. Мөн хоёр үйл ажиллагаа тэгш эрхтэйгээр байвал нэг даалгаврыг хоёр үйл ажиллагаанд хамааруулж кодолсон юм.

Танин мэдэхүйн хүндрэлийн түвшинг онолын хүрээний дагуу дараах гурван түвшингээр ангилсан. Шинэ үзсэн томъёо, тодорхойлолт мэдлэгийг шууд ашиглах бодлогуудыг 1 дүгээр түвшний бодлогууд гэж үзнэ. Олон математик ухагдахууныг холбон бодолт хийж байгаа даалгавруудыг 2 дугаар түвшний даалгаврууд гэж үзэх ба бүтээлч сэтгэлгээ шаардах, эргэцүүлэл хийх, задлан шинжилж, хэрэглэх төрлийн даалгавруудыг 3 дугаар түвшний даалгаврууд гэж үзнэ.

Энэхүү судалгаанд хариултын гурван хэлбэрийг авч үзэв. Эдгээр нь хаалттай хариулт, нээлттэй хариулт, олон сонголттой хариулт гэсэн хэлбэрүүд юм. Олон сонголттой даалгавар

нь аль хэдийн тодорхойлогдсон төгсгөлөг тооны хариултуудыг санал болгоно. Хаалттай хариулттай даалгавар нь нэг зөв (ихэвчлэн богино) хариулт шаарддаг. Нээлттэй хариулттай даалгавар нь математикийн талаарх сурагчдын санаа бодлыг илүү чөлөөтэй илэрхийлэхийг шаарддаг. Хаалттай хариулт нь эцсийн хариултад илүү их анхаарал хандуулдаг бол нээлттэй хариулт нь тодорхой даалгаврыг шийдвэрлэх үйл явц, арга барилтай илүү холбоотой байдаг. Сурах бичгийн харгалзуулан холбох, нөхөх тестийн хариултуудыг олон сонголттой хариулттай бодлого гэж кодлов.

Даалгаврын контекстийг гурван төрлөөр ангилсан. Бодит байдлаас хийсвэрлэн зохиосон даалгавар, бодит амьдрал, туршлагаас сэдэвлэсэн даалгавар болон цэвэр математикийн тэмдэг тэмдэглэгээ, үг хэллэг ашигласан даалгавар гэж гурван төрөлд хуваав.

Өгөгдөл боловсруулах үйл явц: Сурах бичгийн даалгаврыг гурван судлаач хоорондоо хамааралгүйгээр кодолж, хэмжээс бүрийн хувьд үнэлгээ хоорондын найдвартай байдлын коэффициент ашиглан найдвартай байдлыг судалсан. Даалгаврын давтамж, эзлэх хувийг хэмжээс ба анги гэсэн үзүүлэлтээр тооцоолсон. Боловсруулалтыг SPSS-22 программ ашиглан гүйцэтгэв.

Судалгааны Үр дүн

Судалгаанд Монгол улсын бага боловсролын математикийн хичээлд хэрэглэж буй 1-3-дугаар ангийн үндсэн сурах бичгийн даалгавруудыг шинжилсэн ба дараах хүснэгтэд даалгаврын давтамжийг математик үйл ажиллагааны төрлөөс хамааруулан судалсан үр дүнг харуулав.

Хүснэгт 1. 1-3-р ангийн математикийн сурах бичиг дэх даалгаврын давтамж (математик үйл ажиллагааны төрлөөр)

Сурах бичиг	Математик үйл ажиллагаа				Нийт
	Дүрслэх, илэрхийлэх (Н1)	Тооцоолох (Н1)	Тайлбарлах (Н1)	Няцаах эсвэл үндэслэх нотлох (Н1)	
1-р анги	64 (42.7%)	85 (56.7%)	1 (0.6%)	0 (0%)	150 (100%)
2-р анги	317 (37.3%)	502 (59%)	30 (3.5%)	1 (0.2%)	850 (100%)
3-р анги	291 (28.2%)	593 (57.5%)	148 (14.3%)	0 (0%)	1032 (100%)

Хүснэгт 1-ээс харахад 1 дүгээр ангийн математикийн сурах бичигт дүрслэх илэрхийлэх, тооцоолох төрлийн даалгавар зонхилж байгаа бол, 2 ба 3 дугаар ангид эдгээр төрлийн даалгавраас гадна тайлбарлах төрлийн даалгаврууд тодорхой хэмжээгээр нэмэгдэж байна. Харин аль ч ангид няцаах эсвэл үндэслэх нотлох төрлийн даалгавар алга байна.

Хүснэгт 2-т даалгаврын давтамжийг танин мэдэхүйн хүндрэлийн түвшингээс хамааруулан судалсан үр дүнг харуулав.

Хүснэгт 2. 1-3-р ангийн математикийн сурах бичиг дэх даалгаврын давтамж (танин мэдэхүйн хүндрэлийн түвшингээр)

Сурах бичиг	Танин мэдэхүйн хүндрэлийн түвшин			Нийт
	Үндсэн мэдлэг, ур чадварыг шууд хэрэглэх (K1)	Математикийн өөр өөр ухагдахуун, чанар хамтад нь ашиглах (K2)	Бүтээлч мэдлэгийг хэрэгжүүлэх эргэцүүлэн бодох (K3)	
1-р анги	114 (95.8%)	4 (3.4%)	1 (0.8%)	119 (100%)

2-р анги	645 (99.4%)	4 (0.6%)	0 (0%)	649 (100%)
3-р анги	758 (97.2%)	22 (2.8%)	0 (0%)	780 (100%)

Хүснэгт 2-оос харахад 1-3 дугаар ангийн математикийн сурах бичигт үндсэн мэдлэг чадварыг шууд хэрэглэх төрлийн даалгаврууд зонхилж байна.

Хүснэгт 3-д даалгаврын давтамжийг хариултын хэлбэрээс хамааруулан судалсан үр дүнг харуулав.

Хүснэгт 3. 1-3-р ангийн математикийн сурах бичиг дэх даалгаврын давтамж (хариултын хэлбэрээр)

Сурах бичиг	Хариултын хэлбэр			Нийт
	Хаалттай (A1)	Нээлттэй (A2)	Олон сонголттой (A3)	
1-р анги	115 (86.5%)	16 (12%)	2 (1.5%)	133 (100%)
2-р анги	489 (75.4%)	143 (22%)	17 (2.6%)	649 (100%)
3-р анги	518 (66.3%)	248 (31.8%)	15 (1.9%)	781 (100%)

Хүснэгт 3-аас харахад 1-3 дугаар ангийн математикийн сурах бичигт хаалттай хариулттай даалгаврууд зонхилж байгаа ба нээлттэй хариулттай даалгаврууд тодорхой хувиар орж ирсэн, олон сонголттой даалгавар цөөн хувийг эзэлж байна.

Хүснэгт 4-д даалгаврын давтамжийг контекст шинж чанараас нь хамааруулан судалсан үр дүнг харуулав.

Хүснэгт 4. 1-3-р ангийн математикийн сурах бичиг дэх даалгаврын давтамж (контекст шинж чанараар)

Сурах бичиг	Контекст шинж чанар			Нийт
	Цэвэр математикийн (C1)	Зохиомол (C2)	Бодит (C3)	
1-р анги	85 (63.9%)	48 (36.1%)	0 (0%)	133 (100%)
2-р анги	293 (45.2%)	317 (48.8%)	39 (6%)	649 (100%)
3-р анги	390 (50.1%)	329 (42.1%)	62 (8%)	781 (100%)

Хүснэгт 4-өөс харахад 1-3 дугаар ангийн математикийн сурах бичигт цэвэр математикийн контекст болон, бодит үйл явцаас хийсвэрлэсэн контексттэй даалгаврууд зонхилж байна. 2 ба 3 дугаар ангийн сурах бичигт бодит контексттэй даалгавар бага хувийг эзэлж байна.

Судалгааны дүгнэлт ба хэлэлцүүлэг

- 1-3 дугаар ангийн математикийн сурах бичигт дүрслэх илэрхийлэх, тооцоолох төрлийн даалгавар зонхилж, 2-3 дугаар ангид тайлбарлах төрлийн даалгавар бага хувиар нэмэгдэж орсон боловч няцаах эсвэл үндэслэх, нотлох төрлийн даалгавар багтаагүй байна. Энэ нь сурагчдын эргэцүүлэл хийх, задлан шинжлэх чадварт сургахад хангалтгүй юм.
- Танин мэдэхүйн хүндрэлийн хувьд 1 дүгээр түвшний даалгавар зонхилсон буюу аль ч ангид үндсэн мэдлэгийг шууд ашиглах даалгавар дийлэнх байна.
- Даалгаврын хариултын хэлбэрийн хувьд хаалттай хариулттай даалгавар зонхилж, нээлттэй хариулттай даалгавар маш цөөнийг багтаажээ. Нээлттэй хариулттай даалгаврын тоог нэмэх нь сурагчдын танин мэдэх чадварыг хөгжүүлэхэд илүү дэмжлэг үзүүлнэ.
- 1 дүгээр ангийн математикийн сурах бичигт бодит контексттэй даалгавар огт байхгүй, 2 болон 3-р ангид маш цөөн байна. Бодит контексттэй даалгаврын хувьд эх сурвалжийг дурдаагүй байх тохиолдол их байна.

- Цаашдын судалгааны асуудал нь одоо хэрэглэж байгаа сурах бичгийг хэрхэн баялаг даалгавруудтай болгох талаар юм. Хэдийгээр тухайн даалгавар нь цэвэр математикийн, тооцоолох эсвэл хаалттай байсан ч эдгээр даалгаврыг баялаг даалгавар болгон өөрчлөх боломжтой байдаг. Жишээлбэл, зарим хаалттай хариултаас нээлттэй хариулттай даалгавар болгон “Яагаад? Та үүнийг тайлбарлаж чадах уу?” гэх мэт өөрчлөх боломжтой.
- Мөн дараагийн судалгаагаар сурах бичгүүдэд давамгайлж буй даалгаврын онцлог нь сурагчдын математикийн мэдлэг чадвар, ойлголт, дүрслэл, тэдний математикийн чадамжид хэрхэн нөлөөлдөг вэ? Багш нар сурах бичгийг байгаагаар нь шууд ашиглаж байна уу? Багш нар сурах бичгээс өөрөөр зааж байна уу? Эсвэл бусад эх сурвалжийн даалгавартай хослуулж байна уу? Сурах бичиг дэх математик нэр томъёо, үг хэллэг, өгүүлбэр, арга зүйн санаа зэргийг судлах нь сурах бичгийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

Ном зүй

- Fan, L. (2013). Textbook research as scientific research: towards a common ground on issues and methods of research on mathematics textbooks. *ZDM Math Educ.*
- Glasnovic Gracin, D., & Domovic, V. (2009). *Uпотреba matematičkih udžbenika u nastavi viših razreda osnovne škole [Using maths textbooks in lower secondary education]*. Croatian: Odgoj Znan.
- Graham, C. R., & Dziuban, C. D. (2008). Blended Learning Environments. *Handbook of Research on Educational Communications and Technology.*, 269-276.
- Haliday, M. (1973). *Explorations in the Functions of Language*. London: Edward Arnold.
- Huang, Y., & Zhao, N. (2020). Generalized anxiety disorder, depressive symptoms and sleep quality during COVID-19 outbreak in China.
- Love, E., & Pimm, D. (1996). ‘This is so’: a text on texts. In: Bishop AJ, Clements K, Keitel C, et al. , editors. Dordrecht: Kluwer Academic Publishers.
- Stenmark, J. (1991). *Mathematics assessment: myths, models, good questions, and practical*. Reston (VA): National Council of Teachers of Mathematics.
- Vincent, J., & Stacey, K. (2008). Do mathematics textbooks cultivate shallow teaching? Applying the TIMSS video study criteria to Australian eighth-grade mathematics textbooks (хуудас. 82-107).-*Д Math Educ Res J.*
- Yeping, L., & Glenda, L. (2014). *Advancing research and Practice from an International Perspective*. G. L. Yeping Li-Д, *Mathematics Curriculum in School Education* (хуудсд. 11-18). Springer.
- Zhu, Y., & Fan, L. (2006). Focus on the representation of problem types in intended curriculum: a comparison of selected mathematics textbooks from Mainland China and the United States. *Int J Sci Math Educ.*

